

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**

**НОМЫН САН**

# **ШИНЭ НОМЫН МЭДЭЭ №01**

**(2019.01.01-04.01)**



**Эмхэтгэсэн: Номзүйч С.Найгалмаа**

**Ж.Оюунчимэг**

**Улаанбаатар хот**

**2019 он**

## ГАРЧИГ

|                                            |       |
|--------------------------------------------|-------|
| БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН.....               | 1-4   |
| ХИМИЙН ТЕХНОЛОГИ. ХИМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ.....   | 4     |
| ХӨДӨӨ АЖ АХУЙ. ОЙН ШИНЖЛЭХ УХААН.....      | 5     |
| НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                | 5-6   |
| ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                 | 6-13  |
| ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....           | 14-17 |
| УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....              | 17-22 |
| ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....   | 22-26 |
| СОЁЛ.ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ. ....            | 26-32 |
| БОЛОВСРОЛ БА СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН..... | 32    |
| СЭТГҮҮЛ ЗҮЙ.....                           | 33    |
| ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....             | 33-34 |
| АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ.....                    | 34-36 |
| УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ.....                    | 36-37 |
| УРАН ЗОХИОЛ.....                           | 37-42 |
| УРЛАГ БА УРЛАГ СУДЛАЛ.....                 | 42-43 |
| ШАШИНСУДЛАЛ.....                           | 43    |
| ГҮН УХААНЫ ШИНЖЛЭХ УХААН.....              | 43-47 |
| СЭТГЭЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААН .....        | 47-48 |
| ГАДААД ХЭЛ ДЭЭРХИ НОМ.....                 | 48-58 |

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ-Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/  
НХУУТ-Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим /211, 108 тоот/  
ГНОФ-Гэрээр ном олгох фонд /110,201,401 тоот/  
ГФ- Гадаад номын фонд /411 тоот/  
ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/  
БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/  
ХЗС-Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/  
ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын  
сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

# **БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН**



**Хэрэглээний математик:** Коосэнгийн цуврал сурах бичиг / Коосэнгийн математикийн сургалтын хэрэглэгдэхүүний судалгааны баг Ерөн. ред. Ү.Кэнжи, Ёккаши; Орч. А.Амарзаяа, А.Галтбаяр, Д.Даянцолмон; Орч. ред. Ц.Байгалмаа.- Токио: Морикика, 2018.- 218х.- (Японы Үндэсний технологийн хүрээлэн).

Коосэн математик заадаг багш нарын гүйцэтгэсэн энэ цуврал нь суралцагчдад математикийн мөн чанарыг ойлгуулж, түүнийгээ төрөл бүрийн салбарт хэрэглэх үндсийг тавьж өгөхийн зэрэгцээ математикийг амтархан мэдэрч болох ном бүтээхийг зорьсон. Онцлон тэмдэглэхэд энэ номонд тодорхойлолт болон анхнаасаа өгөгдсөн нөхцөлүүд ба тэдгээрээс мөрдөн гарах өгүүлбэрүүд хоёрын ялгааг илүү тодорхой болгосноор ердийн сурах бичгээс давуу талтай.

22.1я73

X-931

/БУУТ-3ш/

ЭШФ Б-29135-29136

**Шугаман алгебр:** Коосэнгийн цуврал сурах бичиг / Коосэнгийн математикийн сургалтын хэрэглэгдэхүүний судалгааны баг Ерөн. ред. Ү.Кэнжи, Ё.Ичи; Орч. А.Амарзаяа, А.Галтбаяр, Д.Даянцолмон; Орч. ред. Ц.Байгалмаа.- Токио: Морикика, 2018.- 172х.- (Японы Үндэсний технологийн хүрээлэн).

Коосэнд самбарын өмнө зогсч математик заадаг багш нарын бүтээсэн энэ цуврал нь суралцагчдад математикийн мөн чанарыг ойлгуулж, түүнийгээ төрөл бүрийн салбарт хэрэглэх үндсийг тавьж өгөхийн зэрэгцээ математикийг амтархан сурах боломжийг бүрдүүлэхэд ердийн сурах бичгээс илүүтэйгээр анхаарал хандуулсан байна.

22.143я73

III-902

/БУУТ-3ш/

ЭШФ Б-29137-29138



**Интеграл ба дифференциал тоолол 1:** Коосэнгийн цуврал сурах бичиг / Коосэнгийн математикийн сургалтын хэрэглэгдэхүүний судалгааны баг Ерөн. ред. Ү.Кэнжи, Ё.Ичи; Орч. А.Амарзаяа, А.Галтбаяр, Д.Даянцолмон; Орч. ред. Ц.Байгалмаа.- Токио: Морикика, 2018.- 172х.- (Японы Үндэсний технологийн хүрээлэн).

Коосэны математикийн багш нарын бүтээсэн энэ цуврал нь суралцагчдад математикийн мөн чанарыг ойлгуулж, түүнийгээ төрөл бүрийн салбарт хэрэглэх чадварт сургахын зэрэгцээ цаашид математикийг амтархан судлах сонирхлыг төрүүлэх агуулгыг багтаахад анхаарал хандуулсан байна.

22.161я73

И-73

/БУУТ-3ш/

ЭШФ Б-29133-29134

Гармаа Д. **Үйлдлийн шинжилгээ:** Их дээд сургуулийн сурах бичиг / Хян. М. Мэнд-Амар.- УБ.: Адмон принт, 2018.- 256х.- (Монгол Улсын Их Сургууль).- ISBN 978-99978-3-078-4.



Энэ сурах бичиг үйлдлийн шинжилгээний үндсэн 11 бүлгийн онол, 50 гаруй жишээ бодлогын бодолт, 600 орчим бодлогыг оруулсан бөгөөд үйлдлийн шинжилгээний бодлогуудыг бодох үндсэн аргуудыг компьютерийн алгоритмын хэлбэрт оруулан томьёолжээ.

22.12я73

Г-269

/БУУТ-7ш, ГНОФ-25ш/

ЭШФ Т-22412-22414



Батмөнх Ш. ба бус. **Статистик судалгааны арга зүй, програм хангамж:**

Их, дээд сургуулийн ахлах курсын оюутан, магистрант, докторант нарт зориулав / Ж.Жамбалдорж, О.Цэрэнбат; Хян. О.Цэрэнбат.- УБ., 2019.- ISBN 978-99973-3-271-4.

Энэхүү гарын авлага нь туршилтын үр дүнд гарган авсан тоон үзүүлэлтийг математик статистикийн аргаар хэрхэн боловсруулах тухай арга зүйн эмхэтгэл юм. 1-р бүлэгт хожим нь танилцах програм хангамжид шаардагдах математик статистикийн болон комбинаторикийн зарим

ойлголт, элементүүдийг багтаасан, 2-р бүлэгт Data Analysis программын хэрэлээг дэлгэрэнгүй жишээний хамт оруулжээ. Энэ бүлэгт түүвэрлэх, зэрэглэл тогтоох, гистограмм байгуулах, корреляци бодох зэрэг энгийн аргуудаас юмс үзэгдлийн шинж чанарын тоон өөрчлөлт, өөрийн зүй тогтолт өөрчлөлтөөс гадна, гаднын тодорхой хүчин зүйлүүдийн нөлөөллөөс болон өөрчлөгддөг зүй тогтолт өөрчлөлтийг тодорхойлох дисперсийн шинжилгээний (ANOVA) аргуудыг тодорхой жишээнүүдэд тулгуурлан тайлбарлан хэрэглэж байгаатай дэлгэрэнгүй танилцах болно.

22.172я7

Б-337

/БУУТ-2ш/

ЭШФ Т-22649-22650

Шигэрү К. **Материалын механик.**- Токио: Jikkyo Shuppan, 2018.- 216х.- (Professional Engineer Library).

“Professional Engineer Library (PEL): Бие даан суралцаж, өөрөө сэтгэн бодож өөрөө мэдлэгээ өндөрсгөх цуврал” бол коосэн, их сургууль, төгсөлтийн дараах сургуулийн суралцагчид санаачлагаараа суралцан, төгсөлтийн дараа бас эзэмшсэн чадвар чадавхаа хэрэглэхдээ, нийтийн эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдлыг бодолцон үзэж, тогтвортой хөгжил, баян тансаг нийгэм байгуулахад цогцоор ашиглаж чаддаг инженер болохыг зорилго болгон хэвлэн гаргасан. ABET, JIABEE, IEA байгууллагуудын GA (Graduate Attributes) шаардлага зэргийг оролцуулан олон улсад хүлээн зөвшөөрөгдөх “инженер” бэлтгэхийн тулд, нэгдсэн үзэл бодолтойгоор” хянан тохиолдуулсан сурах бичиг болно.

22.2я73

Ш-60

/БУУТ-3ш/

ЭШФ Т-22504-22505



Бямба Ж. ба бус. **Монголын геодинамик ба ураны металлогени:**

Монголын геологийн албаны 80 жилийн ойд зориулав / Ю.Б.Миронов, Г.Жамсрандорж; Эмхт. Ш.Алтаншагай, Б.Тимүүжин.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 302х.- ISBN 978-99978-2-461-4.

Уг бүтээлийн эхний хэсэгт плит тектоникийн онол дээр суурилсан тус улсын нутаг дэвсгэрт судлагдаад байгаа литосферийн ба мантийн

бүрдлүүдээр тодорхойлогдсон палеогеодинамикийн байдлуудыг геотектоникийн мөчлөг болгоноор ялгаж, Төв Монголын массивын хэлбэржсэн цаг хугацаа ба механизмын тухай зарим баримтыг дурьдсан. Мөн Дорнод Монголын плюмийн өмнөх мезозойн рифтогенез нь Сибирийн ба Хойд Хятадын тивүүдийн хожуу перм ба түрүү триассын цаг үед Сүлинхээрийн бүсэд явагдсан эх газрын коллизтой цаг хугацаа ба учир шалтгааны холбоотой байж болох тухай санааг дэвшүүлжээ.

26.3(1)

Б-984

/БУУТ-10ш/

ЭШФ Т-22577-22581

**Янжинхүү Ч. Газарзүйн бодлого, дасгал:** Дунд ба ахлах ангийн сурагчид, газарзүйн багш нарт зориулсан гарын авлага: I хэвлэл / Ред. П.Энхжаргал.- УБ.: Сэлэнгэ пресс, 2019.- ISBN 978-99978-4-395-1.

Энэхүү номыг ерөнхий боловсролын сургуульд газарзүйн хичээлийн сургалтыг эрчимжүүлж сурагчдад газарзүйн бодлого бодож сургах, газарзүйн зурагт янз бүрийн хэмжилт хийж тооцоолон бодох дадал эзэмшүүлэх зэргээр сурагчдын бие даасан бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэхэд тус нэмэр болох зорилгоор бүтээжээ. Номонд орсон сэдэв бүрийн эхэнд онолын товч тайлбар өгч, 1-2 бодлого, дасгалыг үлгэрлэн тайлбарлаж бодоод сурагчдаар ажиллуулах дасгалыг оруулан, бодлого, дасгалын хариуг бичсэн нь багш нарын ажиллагааг хөнгөвчлөх, сурагчид бие дааж ажиллаад өөрийгөө шалгахад дөхөм болно гэж үзжээ.

26.8я7

Я-611

/ГНОФ-10ш/

ЭШФ Т-22574-22576



**Кэмпбеллийн биологи: 2 дэвтэр** / Ж.Б.Риз, Л.А.Урри, М.Л.Кейн ба бус.; Орч. Б.Алтанцэцэг, Ш.Анармаа, И.Бадамнямбуу ба бус.; Ерөн. ред. Б.Болдгив; Ред. С.Ундрахболд.- 10 дахь хэвл.- УБ.: Арвис, 2019.- 978-0-321-77565-8.

Энэ сурах бичиг нь МУИС-ийн ерөнхий суурийн “Молекул ба эсийн биологи”, “Организм ба эволюцийн биологи” хичээлүүдийн үндсэн сурах бичиг төдийгүй биологийн мэргэжлийн үндсэн хөтөлбөрүүдэд суралцагсад, бүх түвшинд биологийн хичээл заадаг багш нар, биологийн хичээлээр стандарт шалгалтуудад (SAT, AP гэх мэт) болон биологийн олимпиадад бэлтгэж буй хүмүүсийн гарын авлага болж ирсэн юм. Ийм хэмжээний орчин үеийн биологийн тэргүүлэх сурах бичиг монгол хэлнээ хэвлэгдсэн нь тус улсын түүхэнд анхны тохиолдол болж буй аж.

28.0я73

К-983

Нэгдүгээр дэвтэр.- 750х. ГНОФ 13255-13264

Хоёрдугаар дэвтэр.- 752-1279х.+ Хавср. (104х.) ГНОФ 13265-13274

**Ватсон Ж. Хос эрчлээс:** Тайлбарлаж зурагжуулсан / Орч. Баабар, Л.Амарсанаа.- УБ.: Нэпко, 2018.- 346х.- ISBN 978-99978-51-74-1.

Ватсоны энэ бүтээлийг уншихад детектив роман уншиж байгаа юм шиг хөвөрсөн адал явдалтай бөгөөд бүтээлд ДНХ, ген, хромосом, эс, бөөм,






энерги гэх мэт ойлголтын утга, үүрэг ролийг бүр хачин этгээд байдлаар, заримдаа ид шидийн утгатай ч гэмээр тайлбарласан байна.

28.0

B-215

/БУУТ-5ш/

ЭШФ Т-22660-22662



Отгон Г. **Физиологийн үндэс**: Сурах бичиг / Ерөн. ред. Л.Лхагва, Ц.Лхагвасүрэн.- УБ.: Адмон, 2018.- 422х.- (Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль).- ISBN 978-99929-5-379-9.

Тус сурах бичигт өөрийн орны болон гадаадын эрдэмтэн профессоруудын хүлээн зөвшөөрч баримталдаг хүний физиологийн үүрэг, үйл ажиллагааг тайлбарласан хамгийн сүүлийн үеийн үзэл баримтлал, онолыг тусгасан болно. Агуулгыг нилээд задлан ялгаж, дугаарлан бичсэн нь урьдын уламжлал болсон бичлэгийн хэллэгийг өөрчилсөн. Сэдвүүдийн дотор үйл ажиллагааны зарим механизм нэмэгдэж орсноос гадна “Элэг-ний үйл ажиллагааны талаар шинээр нилээд дэлгэрэнгүй бичигдсэн болно. Мөн “Дасан зохицол”, “Хөдөлмөрийн физиологи”, “Хронофизиологи” зэрэг сэдвүүдийг нэмэлтээр бичжээ.

28.707.3я73

O-535

/БУУТ-2ш/

ЭШФ Т-22415-22416

## **ХИМИЙН ТЕХНОЛОГИ. ХИМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ**

Сүхбаатар И. **Химийн ерөнхий технологи**: Химийн процесс ба реактор: Их сургуулийн үндсэн сурах бичиг / Ред. Б.Баатарсүх, А.Сарнай.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх үйлдвэр, 2018.- 205х.- (Шинжлэх ухаан, технологийн их сургууль. Хэрэглээний шинжлэх ухааны сургууль).- ISBN 978-99978-2-871-2.

Энэхүү сурах бичигт химийн технологийн үндсийг шинжлэх ухааны болоод түүний судалгааны объект болох химийн үйлдвэрлэлийн үүднээс авч үзсэн. Энд химийн процессын онолын зүй тогтлууд болон химийн реакторын онолын үндэс, системийн хандлагад суурилан хими-технологийн процессыг боловсруулах ерөнхий зарчмууд, химийн аж үйлдвэрийн түүхий эдийн ба энергийн баазын талаар оруулжээ.

35

C-861

/БУУТ-7ш/

ЭШФ Т-22417-22419



Авид Б. **Нүүрсний хими, технологи** / Ред. Ж.Дугаржав, Б.Пүрэвсүрэн.- УБ.: Виндзор, 2018.- 168х.- ISBN 978-99978-3-855-1.

Энэхүү нэг сэдэвт бүтээлээр нүүрсний молекул бүтэц, шинж чанар, пиролизын процесс, түүний механизм, хийжүүлэлтийн технологи, хийн генератор, Фишер-Тропшийн реактор, нүүрс шингэрүүлэх технологийн талаарх онолын мэдлэг, ойлголт болон Монгол орны нүүрсний нөөц, насжилт, судлагдсан байдал, томоохон ордын нүүрсний петрограф, хими, халуун задрал, хийжүүлэлт, уусгагчаар хандлан судалсан ажлын дүнг нэгтгэн хүргэжээ.

35.512

A-176

/БУУТ-5ш/

ЭШФ Т-22569-22573

## ХӨДӨӨ АЖ АХУЙ. ОЙН АЖ АХУЙ

**Ойн мэргэжлийн ажилтан:** Гарын авлага / Б.Баярцэцэг, Ч.Ганбаатар, Д.Чулуунцэцэг ба бус.; Хян. Ц.Банзрагч, П.Сувд; Орч. Х.Бадар-Ууган, К.Сакин.- УБ.: Би Си Ай, 2018.- 470х.- (Германы хамтын ажиллагааны нийгэмлэг. Байгаль орчин, аялал жуулчлалын яам).- ISBN 978-99978-4-453-8.



Энэхүү ном нь ойн аж ахуйн арга хэмжээний нийгэм, эдийн засаг, экологи, байгаль хамгаалал, техникийн болон зохион байгуулалтын асуудлуудыг хамарсан заах арга зүйн тойм юм. Номонд багтсан Монгол орны ойн салбарын төлөв байдал болоод Монгол орны ойн экосистемийн онцлогийг тусгасан онолын бүлгүүдийг шинээр боловсруулж, ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын үйл явцыг тогтвортой ойн менежментийг хэдэн зуун жилээр хэрэгжүүлж ирсэн ХБНГУ-ын туршлага дээр үндэслэж, орчуулан толилуулжээ.

43я7

О-239

/БУУТ-10ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-22511-22515



**Ой ба хүлэмжийн хий (Forest and greenhouse gas):** Ерөнхий суурь боловсрол эзэмшихэд зориулсан их сургуулийн гарын авлага / Эмхт. Ц.Батчулуун, Н.Баатарбилэг, Б.Оюунсанаа; Ред. Б.Хишигжаргал.- УБ.: МУИС пресс, 2018.- 151х.- (Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Монгол улсын UN-REDD хөтөлбөр).- ISBN 978-99978-4-541-2.

Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд олон улсын туршлага зайлшгүй чухал бөгөөд REDD+ (Ойн доройтол, хомсдолоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хөтөлбөр)-ийн ерөнхий ойлголтыг багтаасан сургалтын гарын авлагыг оюутан суралцагчдад зориулсан бэлтгэжээ. Мөн ерөнхий болон нарийн мэргэжлийн сэдвүүдийг агуулах ба уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицоход ойн оруулах хувь нэмэр, Монгол улсын төрөөс баримталж буй бодлого, зорилго, зорилтод нийцсэн олон улс (REDD+)-ын бодлого, арга хэмжээг боловсруулахад шаардлагатай мэдээллийг гарын авлагад оруулсан.

43я73

О-239

/БУУТ-20ш, ГНОФ-25ш/

ЭШФ Т-22506-22510

## НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

**Галиндэв Б. Нийгмийн эрсдэл ба ёс суртахууны асуудал тэргүүт өгүүлэл, судлал, шүүмж, бичил нийтлэлүүд / Ред. Х.Энхтуяа.- УБ.: Сэлэнгэпресс, 2018.- 456х.- ISBN 978-99978-3-031-9.**

Энэхүү эмхэтгэлийн эхний бүлэгт монголын нийгмийн ёс суртахуун асуудлыг хөндсөн өгүүлэл, илтгэлүүдийг багтаасан. Мөн буддын шашны гол үндэслэлүүд, агуулгыг тайлбарлаж таниулах, түүний үзэл номлол манай нийгэмд хэрхэн хэрэгжиж байгааг судалж шинжлэх санаа агуулсан нэлээд өгүүлэл илтгэл, “Достоевский ба хүний асуудал” номын нэг бүлгийг уншигчдад хялбарчилж, хүртээмжтэй хүргэх зорилгоор товчилж оруулсан бөгөөд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшилд зориулан “Эцэг эхийн ном” бүтээлээ хамруулжээ.



60

Г-199

/НХУУТ-2ш/

ЭШФ Т-22456-22458



Жаргалсайхан Д. **Хувь хүний эрх чөлөө**: Нийгэм, хувь хүний тухай нийтлэлүүд / Ред. Г.Жавзмаа, Г.Батхишиг.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 344х.- ISBN 978-99978-3-185-9.

Энэхүү номонд зохиогч хувь хүний оролцоо болон иргэний нийгмийн асуудлуудаар бичсэн нийтлэлүүдээ түүвэрлэжээ. Нийтлэл бүрт тухайн асуудлын бодит дүр төрх, үүссэн шалтгааныг тодруулах, оновчтой шийдэхийн төлөө онол болон бусад улс орнуудын туршлагад суурилан, тоо баримттай бичсэн. Хүн болгон эрх чөлөөгөө, хувийн өмчөө хамгаалахын төлөө дуугардаг, шүүмжилдэг, жагсдаг болсон цагт л эрх мэдэлтнүүдийн дур зорго хумигдана гээд иргэдийг өөрийнхөө эрх чөлөөний төлөө дуугарах тэмцэлд уриалж, эх орноо жинхэнэ ардчилсан, цэцэглэн хөгжсөн гүрэн болгохын төлөө хүн бүр хүч чадал, авьяас мэдлэг, боловсрол туршлагаа дайчилж, нэгдэн ажиллах ёстой гэсэн гол санааг агуулсан.

60

Ж-316

/НХУУТ-3ш/

ЭШФ Б-29038-29039

Смелзер Н. **Социологи** / Орч. ред. Ү.Нямдорж.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 514х.- (ШУА. Философийн хүрээлэн).- ISBN 978-99978-945-7-1.



Н.Смелзерийн эрдэм судлалын арвин туршлагадаа тулгуурлан бичсэн уг бүтээл нь социологийн шинжлэх ухааны ерөнхий онол, арга зүйн тодорхой мэдлэгийг багтаасан ба их, дээд сургуулийн оюутан суралцагсад зориулсан сурах бичиг хэлбэрээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл бөгөөд энэхүү бүтээлийг монгол хэлнээ хоёр дахь удаагаа нэмэн сайжруулж хэвлэсэн сурах бичгийг уншигч танаа толилуулж байна.

60.5

С-48

/НХУУТ-7ш/

ЭШФ Т-22651-22653

### ТҮҮХ. ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Харари Ю.Н. **Сапиенс: Хүн төрөлхтний товч түүх** / Орч. Б.Төмөр, Ч.Баасанжаргал, Т.Ариунсанаа; Ерөн. ред. Г.Сугиррагчаа, Ред. С.Ууганбаяр, Л.Энхсайхан.- УБ.: Мон судар, 2017.- 428х.- ISBN 978-99973-1-390-4.

Энэхүү номд хүн төрөлхтний түүхийг цогцоор авч үзэн, хүн анх алхах болсноос авахуулаад өнөөг хүртэл эрээнтэй бараантай түүхийг танин мэдэхүйн, хөдөө аж ахуйн, шинжлэх ухааны хэмээх гурван хувьсгалд хуваажээ. Биологи, антропологи, палеонтологи, эдийн засгийн зэрэг ухаануудын суурь ухагдахуунд үндэслэн, хүн төрөлхтний нийгмүүдийн түүхийг ан амьтан, ургамал ногоо, тэр ч



бүү хэл хүний араншин хүртэл бүрдэл бүрээр задлан шинжилжээ.

63.3(0)

X-236

/НХУУТ-7, ГНОФ-5ш/

ЭШФ Т-22582-22584

Мягмарсамбуу Г. **Баргын түүх, угсаатны зүй**: 3 боть / Ред. Ж.Болдбаатар, С.Чулуун.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- (Монгол Улсын Шинжлэх ухааны академи. Түүх, археологийн хүрээлэн).- ISBN 978-99978-3-436-2.

2014-2016 онд хэрэгжүүлсэн “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн болон угсаа гарлын цогц судалгаа” (ShUTT 002/2014) сэдэвт төслийн хүрээнд

“Монгол улсын Баргууд” сэдвээр судалгаа явуулж, Баргын угсаа гарал, соёл, зан үйлийн талаар судалгааны тайлан бичжээ. Харин энэ удаа дээр

дурдсан төслийн үр дүнд гаргасан ном, судалгааны тайлангийн бүтэц, агуулга, хамраг хүрээг өргөжүүлэн шинэчилж, мөн Манлайбаатар Дамдинсүрэнгийн намтар судлалын бүтээлтэйгээ хамтатган “Баргын түүх, угсаатны зүй” хэмээх гурван боть бүтээл болгон “Баргажин-2018” наадмыг тохиолдуулан хэвлүүлжээ. Үүний гол зорилго нь Монголын угсаатны бүлгийн нэгэн болох Баргын угсаа гарвал, түүхэн уламжлал, түүхт хүмүүс болон тэдний шашин, соёл, зан үйл, Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурийн талаар уншигч, сонирхогчдод нэгдсэн ойлголт өгөхөд оршино.

63.3(1)

M-985

**Б.1.** Баргын түүхэн товчоон: (1734-1960): / Ред. Ж.Болдбаатар.- 335х. ЭШФ Т-22475-22477

**Б.2.** Баргын угсаатны зүй / Ред. С.Чулуун.- 308х.

ЭШФ Т-22478-22480

**Б.3.** Цэргийн жанжин Манлайбаатар Жамсрангийн Дамдинсүрэн: 1871-1921он /Ред. С.Чулуун.- 269х.

ЭШФ Т-22481-22483



**Цэвээн Ж. Ордос дахь Чингисийн онгон**: 1910 онд Өмнөд Монголд зорчсон тэмдэглэлээс / Орч. Д.Бадамням.- УБ.: Цоморлиг төв, 2002.- 56х.- (Монголын Үндэсний түүхийн музей).

Эрдэмтэн Ж.Цэвээн 1910 онд Өвөр Монгол Ордос нутгаар эрдэм судлалын ажлаар зорчихдоо Эзэн Богд Чингисийн онгонд очиж, судалгаа хийсэн тухайгаа тэмдэглэн бичиж хэвлүүлсэн нь эдүгээ ховордож, ахмад орчуулагч Д.Бадамням уг тэмдэглэлийг монгол хэлнээ орчуулсныг Чингис хааны мэндэлсний 840 жилийг ойг тохиолдуулан Монголын Үндэсний

түүхийн музей эрхлэн хэвлүүлжээ.

63.3(1)

Ц-926

ЭШФ Б-29129-29130

**XX зууны Монгол улс 1954-1989**: Сэргэн мандалт, бүтээн байгуулалтын замд: 20<sup>th</sup> Century Mongolia: The road to renewal and creation / Г.Ариунтуяа, Ч.Батдорж, Ж.Болдбаатар ба бус.; Ерөн. ред. Д.Сүхбаатар; Зөвл. Ж.Болдбаатар; Орч. Б.Ган-Очир; Орч. хян. Б.Дашдулам, Т.Стефани.- УБ.:




Мөнхийн үсэг, 2018.- 177х.- (Монголын Үндэсний музей).- ISBN 978-99978-748-0-1.

Монголын Үндэсний музейн сан хөмрөгт хадгалагдаж буй 1954-1980-аад оны сүүл үед холбогдох 150 гаруй үзмэр, эд өлгийн зүйлсийг сорчлон шилж, дагалдах судалгааны өгүүлэл, хураангуй тайлбар, өнгөт гэрэл зургийн хамт энэхүү шилдэг үзмэрийн дээжис цомогтоо багтаан монгол, англи хэл дээр хэвлэсэн. Музейн үзмэр нь шинжлэх ухааны баримт нотолгоо болж, тухайн цаг үед болсон түүхийг өөр өөрийн өнцгөөс амилуулж байдгаараа судалгааны өргөн их ач холбогдолтой билээ.

63.3(1)

X-501

ЭШФ Т-22552-22554



**Монголчууд:** Талын нүүдэлчдийн уламжлал: Нэн эртнээс XII зууны эхэн / Б.Цогтбаатар, Ц.Төрбат, Ч.Амартүвшин ба бус.; Ерөн. ред. У.Эрдэнэбат; Ред. Р.Энхбат, Л.Энхсайхан.- УБ.: Монсудар, 2018.- 264х.: Өнгөт зур.- ISBN 978-99973-1-613-4.

Энэхүү ном агуулгын хувьд түүхийн асар урт цаг хугацааг хамарч байгаа ч монгол угсаатан бүрэлдэн тогтоход өөр өөрсдийн хувь нэмрийг оруулсан эртний нүүдэлчдийн түүхийг 8 бүлэгт багтаан толитуулжээ. Өөрөөр хэлбэл 800 000 жилийн тэртээ өнөөгийн Монгол нутгаар хэрэн хэсэж асан эртний хүмүүсээс эхлээд, ахуй соёлын хувьд нэгэн нийтлэгийг бий болгож, нэгдмэл улс төрийн хүчин болсон Их Монгол Улс байгуулагдахын өмнөх үеийн нүүдэлчин ард түмнүүдийн түүхийг энгийн ойлгомжтой бичлэгийн хэв маягт буулган өгүүлсэн. Эрт цагаас үлдэж хоцорсон булш оршуулга, хиргисүүр, буган хөшөө, хүн чулуу зэрэг дурсгалууд бидэнд түүхийн ямар нууцыг өртөөлөн хадгалсныг хийгээд бидний өвөг дээдэс хэрхэн амьдарч ирснийг уг номоос цогцоор нь мэдэх боломжтой.

63.3(1)

M-69я6

ЭШФ Т-22641-22643

**Болдын Дамбаравжаа:** Ардын партизан: Алтанбулагийн яамны сайд: Үндэсний төв музейн дарга / Эмхт. С.Баатар, Д.Лхамсүрэн; Хян. Ж.Саруулбуян, Х.Мэндсайхан.- УБ., 2012.- 66х.- (Монголын Үндэсний музей).- ISBN 978-99962-2-308-2.

Энэхүү номонд Б.Дамбаравжаагийн товч намтар, 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгал, Ардын засгийн үйл хэрэгт идэвхийлэн музейг хөгжүүлэхэд гар бие оролцож нягтлан бодохоос даргын ажлыг хүртэлх албыг хашиж байсан талаарх аман түүх болон архивын хөмрөг, хувийн цуглуулгад хадгалагдаж байсан урьд судалгааны эргэлтэд ороогүй шинэ баримтуудыг эш хэрэглэгдэхүүн болгосон нь музейн талаар дорвитой бүтээлүүд үгүйлэгдсээр байгаа өнөө үед цаг үеэ олсон шинэлэг бүтээл болсон.

63.3(1)-8

Б-111

ЭШФ Б-29124-29125



**Ичинноров С. 1921 оны хувьсгалын удирдагчийн нэг Дансранбилэгийн Догсом** / Хян. Ж.Саруулбуян.- УБ., 2012.- 149х.- (Монголын Үндэсний музей).- ISBN 978-99962-2-111-8.

Энэхүү бүтээл нь хувьсгалт тэмцлийн замналыг шинээр нээн харуулахад тодорхой зам мөр болох буй за. Ардын хувьсгалын анхны долоогийн нэг, шинэ Монголын төрийн шилдэг зүтгэлтэн, бичгийн утгач Д.Догсом нь Монгол ардын намыг анхлан байгуулагчдын нэг болохыг түүхчид нэгэнт нотолжээ. Д.Догсом нь олонд түгсэн дуунууд, улс төр ухуулгын аятай олон шүлэг зохиол бичсэнийг энэхүү бүтээлд дурдсан байна.

63.3(1)-8

И-967

ЭШФ Б-29131-29132

Цэвээн Ж. **Түүвэр зохиолууд** / Эмхт. С.Идшинноров.- УБ.: Тана, 1997.- 214х.- (Монголын Үндэсний түүхийн музей).

Энэ дэвтэрт орсон “Нэрт эрдэмтэн, нийгмийн зүтгэлтэн Жамсраны Цэвээн” өгүүллийг философийн ухааны дэд доктор Дашжамц бичиж, “Ард Жамсраны Цэвээнээс Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороонд” бичсэн өргөдлийг шинэ бичигт буулган оруулжээ. Мөн “Улсын эрх” зохиол, “Монголын Хувьсгалт Залуучуудын эвлэл ба буддын шашин”, “Рерихээс орос хэл дээр Улаанбаатарт 1926 ба 1927 онд Буддын ёсны үндэс ба сангха буюу община” хэмээх дэвтэр хоёрыг нийтлүүлсэн тухай тайлбар, “Монгол улсын эрдэм шинжилгээний ажлын ач холбогдол”, “Монгол орны газар орны байдал” зохиолууд, Хөвсгөл нуурын дархад, урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, захчин, мянгад, торгууд, хошууд, дарьганга, алтайн урианхай, хасаг, хамниган нарын гарал үндэс, байдлын өгүүлэл зохиолыг шинэ бичигт буулгаж, Ж.Цэвээний бусадтай харилцсан захидлуудыг ч орчуулан оруулжээ.



63.3(1)-8

Ц-926

ЭШФ Б-29119-29120



Хайсандай Л. **Академич Чулууны Далай**: Академич Ч.Далай бол Монголын түүх, Дорно дахин судлалын тэргүүлэх эрдэмтэн мөн / Ред. Д.Золбоо.- УБ.: ТЭПЭ., 2018.- 52х.- (Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Олон улс судлалын хүрээлэн).- ISBN 978-99978-763-2-4.

Энэхүү бэсрэг товхимол Ч.Далайн 80 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд доктор Л.Хайсандай багшийн хэлсэн үг, илтгэлүүдийг нэгтгэн өмнөх хэвлэлийн алдаа мадагийг залруулан нэмж засварлан 2 дахь хэвлэлийг толилуулжээ. Илтгэлд Ч.Далайн туурвисан ном бүтээлийн тойм, жагсаалтыг тусгасан.

63.3(1)-8

Х-177

/НХУУТ-3ш/

ЭШФ Б-29150-29151

**Зүүн Байдлагийн голын сав дахь археологийн дурсгалууд**: Монголын археологийн шинэ судалгаа: Цувр.V / Ч. Амартүвшин, Б.Бадма-Оюу, Л.Ишцэрэн ба бус.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 287х.- (Шинжлэх ухааны академи. Түүх, археологийн хүрээлэн).- ISBN 978-99978-3-639-7.

Энэхүү хамтарсан судалгааны бүтээл нь эртний нүүдэлчдийн үйлдвэрлэлийн түүхийг судлан шинжлэхэд чиглэгдэж байгаа хэдий ч тухайн үеийн үйлдвэрлэл эрхлэгчдийн амьдралын хэв маяг, үхэгсдээ



оршуулах зан үйл, өмнөх болон хожмын нүүдэлчдийн угсаа гарал, зан үйлийн залгамж холбоог ямар нэгэн хэмжээгээр цогц байдалтай судлахад чиглэгдэж байсныг харуулсан. Бүтээлийг Монгол Улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрэлээн, Ерөнхий болон сорилын биологийн хүрэлээн, МУ-ын Боловсролын их сургуулийн 8 судлаач, Япон улсын Эхимэ, Тохокү, Саппоро гакүин, Сайтама, Кокүгакүин, Нара, Токай, Айчи гакүин, Окасагийн их сургууль, Токүшима аймгийн Соёлын өвийн төвийн 10 судлаач хамтран туурвижээ.

63.4(1)

3-925

/НХУУТ-5ш/

ЭШФ Т-22442-22446



Сүхбаатар Д. **Монгол орны хадны зураг: The petroglyphs of Mongolia II** / Хян. П.Дэлгэржаргал; Орч. М.Мөнгөнцэцэг; Орч. ред. В.Тэйлор.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 168х.- (Монголын Үндэсний музей).- ISBN 978-99962-3-823-9.

Энэхүү цуврал зурагт цомог нь Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших Бага Ойгор, Цагаан салаа голын сав газрын 15 километр орчим талбайд тархсан олон мянган хадны зургийн зохиомжоос сорчлон авч олон нийтэд зориулсон бүтээл болно. Ихэнх зураг дүрслэлийг цохиж цоолборлох аргаар сийлж үлдээсэн хадны зурагт эртний хүмүүсийн амьдрал ахуйг дүрслэхээс гадна буга, янгир, аргаль, чоно, ирвэс, баавгай, бодон гахай, үхэр, адуу, тэмээ зэрэг олон амьтдыг дүрсэлж, морь, үхэр, тэмээ унасан хүн, морин тэрэг, ан гөрөө хийж багаа анчид, байлдаж буй дайчин эрс зэрэг олон сэдвийг зохиомжлон зурсан нь сонирхол татахуйц урлагийн бүтээл юм. Энэхүү баялаг түүхэн дурсгалыг монгол, англи хэл дээр хэвлэжээ.

63.4(1)

С 861

ЭШФ Б-29159-29160

Сонгуульхүү Н. **Монгол бадарчин** / Ред. А.Очир.- УБ.: Бит пресс, 2018.- 144х.- ISBN 978-99978-3-583-3.

Уг зохиолд, бадарчин хэмээх бүлэг хүмүүс үүссэн нийгэм, түүхийн нөхцөл шалтгааныг нэлээд үндэслэлтэйгээр тодорхойлон гаргаж өгсөн байна. Түүнчлэн монгол бадарчин нарын нийгмийн ерөнхий дүр төрх, тэдний эдэлж хэрэглэж агсан хувцас хунар, бусад зүйлийг нэлээд нарийн тодорхойлон гаргажээ. Чингэхдээ лам, хар, настан өтгөсийг сурвалжлан, холбогдох зарим мэдээг цуглуулжээ. Зохиолд өгүүлснээр, бадарчин нь Монгол ардын аман зохиолын, түүний дотор хошин шог, үлгэр домгийн нэгэн гол баатар болж чадсан байна.



63.5(1)

С-568

/НХУУТ-2ш/

ЭШФ Б-29043-29045



**Монголчуудын хойлгын зан үйл:** Уламжлал- орчин үе - чиг хандлага: Эрдэм шинжилгээний хоёрдугаар хурал / Ред. П.Дэлгэржаргал; Эмхт. Э.Жигмэддорж, Г.Идэрмаа.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 304х.- (Монгол Улсын Их Сургууль. Түүхийн тэнхим. Улаанбаатар хотын Нийслэлийн захирагчийн ажлын алба. “Буяны зан үйлийн холбоо” ТББ).- ISBN 978-99978-791-2-7.

Энэхүү эмхэтгэлд “Монголчуудын оршуулгын зан үйл: уламжлал, орчин үе, чиг хандлага” эрдэм шинжилгээний хоёрдугаар хурлын материал болон монголчуудын хойлгын зан үйлтэй холбогдох зарим өгүүллийг оруулжээ. Эрдэм шинжилгээний хурлаар Монгол нутаг дахь чулуун зэвсгийн үеийн оршуулгын зан үйлээс эхлэн эртний нүүдэлчдийн гашуу тайлах ёсон, эрт, дунд болон орчин үеийн монголчуудын оршуулгын зан үйл, үе тус бүрийн онцлог, хувирал, өөрчлөлт, Монголын угсаатны бүлгүүдийн оршуулгын зан үйлийн өвөрмөц тал, Монгол дахь исламын болон христ шашинтны оршуулгын зан үйл, Улаанбаатар хотын оршуулгын өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага, тулгамдсан асуудал зэргийг цогц байдлаар шинжлэх ухааны олон салбар үүднээс судлан шинжилж, судалгааны үр дүнг хэлэлцүүлжээ.

63.5(1)

М-694

/НХУУТ-2ш/

ЭШФ Т-22676-22678

**Bulletin The IAMS News Information on Mongol Studies №2(12), №1(13) /**  
Editor Ш.Бира.- УБ., 1993-1994.- 136р.

In this issue: Igor de Rachewitz. The History of the Mongols: Some Fundamental problems, Sh.Bira. The Mongol Empire (13<sup>th</sup>-14<sup>th</sup> cc): The east and West Relations, Б.Базылхан. Тоньюкукийн түрэг руни бичээс, The IAMS News and News from the National Centres.



63.3(1)

В-93

ЭШФ Т-22374



**Bulletin= Монгол судлалын мэдээлэл №2(42), №1(43) /** Ред. Ш.Бира.- УБ., 2008-2009.- 171х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

“Аав хүү Перих нар ба Монгол” хэмээх олон улсын симпозиумын материал, оролцогчдын илтгэлүүдийг сэтгүүлийн энэ дугаарт багтаасан байна.

63.3(1)

В-93

ЭШФ Т-22378

**Bulletin= Монгол судлалын мэдээлэл №2(44), №1(45) /** Ред. Ш.Бира.- УБ., 2009-2010.- 181х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

2009 онд зохион байгуулсан “Үндэсний Монгол судлалын төлөв байдал, зорилт” сэдэвт бага хурлын материал, илтгэлүүд, монгол судлалын анхдугаар их хурлын тухай эрдэмтний дурсамж, 2009 онд монгол судлалын чиглэлээр хэвлэгдсэн шинэ номын тойм орсон байна.



63.3(1)

В-93

ЭШФ Т-22379





**Bulletin= Монгол судлалын мэдээлэл №1(46)** / Ред. Д.Төмөртоогоо.- УБ., 2012.- 114х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

Олон улсын Монголч эрдэмтдийн X их хурлын тухай мэдээлэл, илтгэлүүдийн жагсаалт, 2011 онд УБ хотноо зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын мэдээлэл, монгол судлалын чиглэлээр 2010-2011 онд хэвлэгдсэн шинэ номын тойм, ОУМЭ-ийн арван их хурлын тухай мэдээлэл, эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлүүдэд 2013 онд нийтлэгдсэн өгүүллийн жагсаалт зэрэг чухал мэдээ мэдээллийг багтаан эмхтгэжээ.

63.3(1)

В-93

ЭШФ Т-22366

**Bulletin= Монгол судлалын мэдээлэл №2(47)** / Ред. С.Чулуун.- УБ., 2012.- 112х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

2012 онд дотоод, гадаадад зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын мэдээлэл, монгол судлалын чиглэлээр хэвлэгдсэн шинэ номын тойм, профессор Н.Хурцбилэг, Пак Вон Гил нарын эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт орсон байна.



63.3(1)

В-93

ЭШФ Т-22380



**Bulletin= Монгол судлалын мэдээлэл №1 (48)** / Ред. Д.Төмөртоогоо.- УБ., 2013.- 124х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

2013 онд дотоод болон гадаадад зохион байгуулагдсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын мэдээлэлүүд, монгол судлалын чиглэлээр хэвлэгдсэн шинэ номын тойм, мэдээлэл, монгол судлаач эрдэмтдийн бүтээлийн жагсаалтуудыг оруулсан.

63.3(1)

В-93

ЭШФ Т-22367

**Bulletin= Монгол судлалын мэдээлэл №2(49)** / Ред. Д.Төмөртоогоо.- УБ., 2013.- 140х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

Сэтгүүлийн энэ дугаарт 2013 онд дотоод болон гадаадад зохион байгуулагдсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын мэдээлэлүүд, эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлүүдэд 2013 онд нийтлэгдсэн өгүүллийн жагсаалт, монгол судлалын чиглэлээр хэвлэгдсэн шинэ номын тойм, шүүмж, монгол судлаач эрдэмтдийн бүтээлийн жагсаалтууд оржээ.



63.3(1)

В-93

ЭШФ Т-22381



**Bulletin=Монгол судлалын мэдээлэл: №1(50)** / Ред. Д.Төмөртоогоо.- УБ., 2014.- 156х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

2014 онд дотоод, гадаадад зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын мэдээлэлүүд, шинэ номын тойм, шүүмж, монгол судлаач эрдэмтдийн дурсамж, бүтээлийн жагсаалт зэргийг багтаан эмхтгэсэн.

63.3(1)

В-93

ЭШФ Т-22368

**Bulletin=Монгол судлалын мэдээлэл: №2(51)** / Ред. Д.Төмөртоогоо.- УБ., 2014.- 228х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.



Олон улсын Монгол Судлалын Холбооноос эрхлэн хэвлүүлсэн сэтгүүлийн энэ дугаарт 2014 онд зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын мэдээлэлүүд, эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлүүдэд 2014 онд нийтлэгдсэн өгүүллийн жагсаалт, монгол судлаач эрдэмтдийн дурсамж, бүтээлийн жагсаалт зэргийг багтаажээ.

63.3(1)

В-93

ЭШФ Т-22382



**Bulletin=Монгол судлалын мэдээлэл №1(52)** / Ред. Д.Төмөртоогоо.- УБ., 2015.- 206х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

2015 онд дотоод, гадаадад зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлууд болон бусад хурлын мэдээ, УБ хот дахь Америкийн Монгол судлалын төвийн цуврал лекцүүд-2015 мэдээлэл, эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлүүдэд нийтлэгдсэн өгүүллийн жагсаалт, шинэ номын тойм, шүүмж, монгол судлаач эрдэмтдийн бүтээлийн жагсаалт зэргийг эмхтгэсэн.

63.3(1)

В-93

ЭШФ Т-22369

**Bulletin= Монгол судлалын мэдээлэл №1(54)** / Ред. Д.Төмөртоогоо.- УБ., 2016.- 198х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.



2016 онд дотоод, гадаадад зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын мэдээлэл, эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлүүдэд 2016 онд нийтлэгдсэн өгүүллийн жагсаалт, монгол судлалын чиглэлээр хэвлэгдсэн шинэ номын тойм, шүүмж, монгол судлаач эрдэмтдийн бүтээлийн жагсаалтууд орсон байна.

63.3(1)

В-93

ЭШФ Т-22370



**Bulletin= Монгол судлалын мэдээлэл №2(55)** / Ред. С.Чулуун.- УБ., 2016.- 237х.- (Олон Улсын Монгол Судлалын Холбоо=The IAMS News Information on Mongol Studies).- ISSN 1024-3135.

2016 онд дотоод, гадаадад зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлуудын мэдээлэл, эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлүүдэд 2016 онд нийтлэгдсэн өгүүллийн жагсаалт, монгол судлалын чиглэлээр хэвлэгдсэн шинэ номын тойм, шүүмж, монгол судлаач эрдэмтдийн бүтээлийн жагсаалтууд орсон байна.

63.3(1)

В-93

ЭШФ Т-22383

Урангуа Ж., Эрдэнэбилэг Б. **Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан япончууд** / Зөвл. Б.Хүсэл.- УБ., 2018.- 274х.- (МУИС. ТЕГ. Шова эмэгтэйчүүдийн их сургууль).- ISBN 978-99978-4-854-3.



Энэхүү номонд Дэлхийн II дайны төгсгөлийн шат болох Азийг чөлөөлөх дайны асуудлууд, түүнд БНМАУ оролцсон хийгээд тэртээ 1945-1947 онд дайн олзны хүмүүс болон БНМАУ-д 2 жил орчим ажиллаж амьдарч байсан 12326 япон хүмүүс хэрхэн тэс улсад ирсэн, Монголд ажилласан болон эх орондоо буцсаны дараах үеийн түүх болон өнөө үеийн талаар өгүүлэх болно.

63.3(5)62

У 958

НХУУТ 50 72015-72022

## ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Жаргалсайхан Д. **Эдийн засгийн эрх чөлөө: Эдийн засгийн тухай нийтлэлүүд** / Ред. Г.Жавзмаа, Г.Батхишиг.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 368х.- ISBN 978-99978-3-184-2.

Энэхүү ном нь зохиогчийн эдийн засгийн чиглэлээр 2014-2017 онуудад бичсэн нийтлэлүүдийн багц юм. Улс орны нийгэм, эдийн засгийн амьдралыг долоо хоног бүрт дүгнэн бичсэн түүний нийтлэлүүд олон мянган хүнд ухаарал, эргэцүүлэн ойлгох боломж олгож ирсэн. Түүнчлэн улс орныхоо хөгжил, ирээдүйн талаар бодож явдаг, өнөөгийн улс төр, нийгмийн өөрчлөлтүүдийн гүнд амьдарч, харж, дүгнэж, бичиж, түгээж, хэлцэж, маргаж ирсэн хүний бүтээл, жинхэнэ “амьд” нийтлэл зургууд юм.

65

Ж-316

/НХУУТ-3ш/

ЭШФ Б-29036-29038

Баяртсайхан Н. **Сорилт** / Ред. Б.Өвгөнхүү; Эмхт. Т.Тэлмэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 260х.- ISBN 978-99978-4-807-9.

Энэхүү бүтээлд Монгол банкны мөнгөний бодлогын түүх, тогтворжилт, зээлийн хүүг бууруулах стратеги хэлэлцүүлэг, Монголын эдийн засгийн чуулга уулзалтын Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтад тавьсан



илтгэл, “Их өр”-ийн асуудлыг шийдвэрлэсэн нь зэрэг судалгааны өгүүлэл нийтлэл, илтгэлүүд орсон бөгөөд түүнчлэн зохиогчийн хэлсэн үг, мэндчилгээ, өдөр тутмын сонин хэвлэлд өгсөн ярилцлага, Монгол улсын гүйлгээний хэрэгслийн түүх, гэрэл зургаар өгүүлэхүй гэх мэт 5 бүлгийг багтаажээ.

65

Б-385

ЭШФ Т-22484-22488



Рэнд А. **Бизнесийн философи**: Айн Рэндийн “Атлантын нуруу тэнийв”-ийн капиталистуудад зориулсан тайлбар толь / Орч. Т.Ариунсанаа; Ред. П.Цэнгүүн.- УБ.: Нэпко, 2018.- 329х.- ISBN 978-99978-51-72-7.

Энэ товхимолд багтаасан нийтлэлүүд бизнес эрхлэгчид хавчлагын эсрэг зогсох ёстой гэсэн байр суурь илэрхийлсэн бөгөөд үүний тулд бизнес эрхлэгчид зохих философиор зэвсэглэх хэрэгтэй ажээ. Нэгдүгээр хэсэгт философи бол асуудлаас зугтах биш харин ч өдөр тутамд хэрэгцээтэй зүйл. Улс төр, эдийн засгийн олон асуудалд нөлөөтэй гэдгийг харуулна.

Хоёрдугаар хэсэгт бизнес эрхлэгчдийг дайрахдаа ямар тактик хэрэглэдгийг философийн үүднээс авч үзнэ. Гуравдугаар хэсэгт хүн амьдралдаа болон бизнест амжилтад хүрэхийн тулд зарчмын хатуу байр суурь баримтлах ёстой болохоос буулт хийх ёсгүй талаар өгүүлсэн. Дөрөвдүгээр хэсэг бизнес эрхлэгчдийг өөрсөд рүү нь шударга бусаар довтолсон довтолгоог сөрөхөд туслах сэтгэлгээний зэвсгээр зэвсэглэх болно.

65.01

Р-964

ГНОФ 13244-13246

Батхишиг Б. **Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал**: Улс төрийн эдийн засгийн ухаан ба экономиксийн судалгаа / Хян. А.Бакей.- УБ.: Бэмби сан, 2018.- 348х.- (Монгол Улсын ШУА-ийн философийн хүрээлэн. Философийн салбарын Улс төрийн эдийн засгийн ухааны тасаг).- ISBN 978-99978-4-471-2.

Философийн хүрээлэнгээс сүүлийн жилүүдэд “Монголын хөгжлийн философи”, “Тогтвортой хөгжлийн оюун санааны үндэс” зэрэг сэдвийг судалж байгаа бөгөөд үүнтэй уялдуулан Монголын эдийн засгийн хөгжлийн асуудлыг шинжлэн судлах зорилт тавьсаны эхний үр дүн нь энэхүү ном болой. Монголын эдийн засгийн хөгжлийн асуудлыг судалж дүгнэхдээ позитив ба норматив эдийн засгийн онолын аль алиныг нь ашигласан. Өөрөөр хэлбэл, Монголын эдийн засгийн хөгжлийн асуудлыг задлан шинжлэхийн хамт, түүнийг хурдасгах арга замыг тодорхойлжээ.

65.01(1)

Б-342

/НХУУТ-5ш/

ЭШФ Т-22437-22441



Смит А. **Үндэсний баялаг**: Мөн чанар, учир шалтгаан / Орч. Ц.Ганбат; Ерөн. ред. Баабар; Ред. Д.Жаргалсайхан, Б.Нэргүй.- УБ.: НЭПКО, 2018.- 992х.- ISBN 978-99978-51-67-3.

ХҮШ зуунд аугаа эрдэмтэн Адам Смит Үндэсний баялаг зохиолоороо эдийн засгийн ухааны нарийн зүй тогтлыг хүн төрөлхтөнд нээж өгсөн явдал юм. Энэхүү бүтээл орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааны суурь гэж

тооцогддог. Хүн л аливаа зүйлс, үзэгдлийг өөрийн, бусдын хэрэгцээг хангах хэрэгсэл болгон хувиргах мэдлэг, ур чадварыг бий болгож, эзэмшиж, бас түүнийгээ ашиглан баялаг бүтээдэг. Алтгүй, нүүрсгүй, зэсгүй боловч мэдлэгээрээ, нягт нямбай хичээнгүй хөдөлмөрөөрөө баялаг бүтээж, үр шимийг нь хүртэж байгаа өчнөөн олон улс, үндэстнүүд нь Адам Смитийн онолын амьдрах чадвартайг нотолж байна.

65.011

C-482

/НХУУТ-6ш/

ЭШФ Т-22428-22431

Мэнкью Н.Г. **Эдийн засгийн ухаан: Макроэкономикс** / Ред. Ц.Даваадорж; Орч. Ш.Батмөнх.- 3 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2019.- 607х.- ISBN 978-99929-989-6-2.



Энэхүү гарын авлагад зах зээлийн эдийн засгийн үндсэн ойлголт болох эрэлт нийлүүлэлтийн шинж чанарыг задлан шинжилж зах зээлийн “үл үзэгдэх” гарын нөлөөг өрсөлдөөнт зах зээлтэй холбон тодорхой тайлбарлаж мөн экономиксийн 10 зарчим, эдийн засагт төрийн оролцооны нөлөө болон нийгмийн халамж, цалин хөлс, имплицит гэх мэт улс орны эдийн засгийн нэн ээдрээтэй онол практикийн олон асуудлыг энгийн ойлгомжтой аргаар тайлбарлан, сэдэв бүрийн хажууд үндсэн ойлголтыг шигтгэж, асуулт, бие даан ажиллах кэйс болон нэр томъёоны англи- монгол толийг хавсаргасан байна.

65.012.2

М 96

/БС- 89 9971-9975/



Мэнкью Н.Г. **Эдийн засгийн ухаан: Микроэкономикс** / Ред. Д.Бямбаа; Орч. Ш.Батмөнх.- 3 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2019.- 333х.- ISBN 978-99929-0-161-6.

Энэхүү гарын авлагад экономиксийн 10 зарчимд тулгуурлан маржинал судалгааны үндсэн дээр шийдвэр гаргах, худалдааны ашиг, урамшуулал, зах зээлийн хуваарилалтын үр ашиг, эрэлт нийлүүлэлт зэрэг үндсэн ойлголтуудыг энгийн ойлгомжтой тайлбарлаж, сүүлийн бүлэгт үйлдвэрлэлийн зохион байгуулалт, бүтээгдэхүүний өртөг, монополь үнийн ойлголтын талаар бодит жишээгээр үзүүлж, сэдэв бүрийн хажууд үндсэн ойлголтыг шигтгэж, асуулт, бие даан ажиллах кэйс болон нэр томъёоны англи- монгол толийг хавсаргасан байна.

65.012.2

М 96

/БС- 89 9966-99770/

Буянтогтох Х. **Банк, санхүүгийн хичээлүүдийн лекц** / Ред. Д.Болдбаатар.- УБ.: Адмон принт, 2019.- 228х.- (Монгол банк).- ISBN 978-99978-68-35-0.




Энэхүү лекцүүд, зохиогчийн хагас зуу гаруй жилийн хугацааны бүтээлийнх нь нэгээхэн хэсэг, товчлол нь юм. Бүтээл нь угаасаа манай оронд банк санхүүгийн шинжлэх ухаан анх судлагдаж эхэлсэн үеэс тэр үеийн монгол хүний гүн ухааны сэтгэлгээгээр бичигдсэн. Зохиогч банк, санхүүгийн асуудлыг хамтад нь өөр хоорондоо диалектик холбоотой авч үзсэнээрээ шинэлэг бүтээл болжээ.



65.26

Б-819

ЭШФ Б-29155-29156



Боди З., Мертон Р.К. **Санхүү** / Хөрв. А.Ганзориг, Ж.Ариунболд, Ч.Аварзэд ба бус.; Хян. А.Ганзориг, Г.Буянтогтох, Ж.Ариунболд ба бус.; Эрхл. А.Ганзориг, Г.Дашдорж.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 636х.- ISBN 978-99978-3-675-5.

Энэхүү сурах бичгийг зохиогчийн нэг Роберт Мертон 1997 онд эдийн засгийн салбарт Нобелийн шагнал хүртсэн бөгөөд орчин үеийн санхүүгийн онолын салбарт Мертоныг их эрдэмтэн Исаак Ньютонтой зүйрлэх болсон нь энэ номын үнэ цэнийг өсгөх юм. Уолл Стрийтэд хэрэглэдэг опционы үнэ, санхүүгийн үүсмэл хэрэгслийг боловсронгуй болгох гээд орчин үед санхүүгийн мэргэжилтний санааг зовоосон олон асуудалд холбогдох хувь хүний санхүү, капиталыг төсөвлөх, үйлдвэрлэх ажлын эдийн засаг, аж ахуйн нэгжийн ажлын үр ашгийг шинжлэх зэрэг агуулгыг уг номонд багтаасан байна.

65.261я73

Б-53

БС-89 9956-9965

Батжаргал Б. **Нийгмийн даатгал-тэтгэвэр, тэтгэмж бодох арга зүй**: Ажил олгогч, даатгуулагч, нийгмийн даатгалын байцаагч, ажилтан, суралцагчдад зориулсан гарын авлага / Ерөн. ред. Д.Далхжав; Хян. Г.Бурмаа.- УБ.: Удам соёл, 2019.- 185х.- ISBN 978-99978-68-29-9.



Энэ номонд нийгмийн даатгалын харилцаа нь эхлээд шимтгэл төлж даатгуулах, дараа нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах цикл байдгийг харгалзан нийгмийн даатгалд хамрагдах хэлбэр, шимтгэлийн тухай эхний бүлэгт, дараагийн бүлэгт нь нийгмийн даатгалын хууль тогтоомжид зааснаар олгох ажилгүйдэл, эрүүл мэнд, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, цэргийн гэх мэт тэтгэвэр, тэтгэмж бодох арга зүйг нэг бүрчлэн жишээ авч тайлбарласан байна.

65.272

Б-335

БС- 89 9991-10000



Дорж Т. **Менежмент**: Сурах бичиг / Ред. А.Бакей, Д.Энх-Отгон.- УБ.: МУИС пресс, 2018.- 514х.- (Монгол Улсын Их Сургууль. Бизнесийн сургууль. Улаанбаатар Эрдэм их сургууль).- ISBN 978-99978-4-516-0.

Энэхүү сурах бичиг менежментийн шинжлэх ухааны үүсэл, хөгжил, зорилго, судлагдахуун, судлах арга, онол, сургаалыг Монголын нөхцөл дэх менежментийн онцлогуудтай нягт уялдуулан тодорхойлсны зэрэгцээ байгууллагын түвшин дэх менежментийн чиг үүрэг, орчин, бизнес эрхлэлтийн ёс зүй, зан төлөв зэрэг асуудлыг орчин үеийн өөрчлөлтийн хандлагуудтай холбон үзэж, менежментийн шинжлэх ухааны амин чухал асуудал болох харилцаа, түүний арга барил, төслийн менежмент, удирдлагын шийдвэр гаргах онол, арга зүйн үндсийг тусгаж, стратегийн төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөцийн бүрдүүлэлт,

идэвхжүүлэлт, хяналт зэрэг менежментийн чиг үүргийн талаар гадаад орнуудын эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан бичсэн нь сонирхолтой болжээ.

65.290-2я73

Д-542

/НХУУТ-4ш, ГНОФ- 3ш, БС-10ш/

ЭШФ Т-22425-22427

Мягмаржав И., Мягмарцэрэн П. **Газрын төлөв байдал, чанар, тохиромжтой байдлын үнэлгээ.**- УБ.: GZ press, 2018.- 200х.- ISBN 978-99978-3-766-0.


Газрын менежмент, газрын кадастр, газрын эдийн засаг, үнэлгээ, газрын харилцааны зохицуулалтын асуудлыг шинжлэх ухааны үүднээс нарийвчлан судалсан энэхүү нэг сэдэвт бүтээлийг тухайн салбарын мэргэжлийн ангийн оюутан, магистрант, эрдэм шинжилгээ, судалгааны ажилтнууд, бусад сонирхогчдод зориулан хэвлэжээ.

65.32-5

М-985

/БУУТ-10ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-22420-22424



### УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН



Жаргалсайхан Д. **Улс төрийн эрх чөлөө:** Нийтийн засаглалын тухай нийтлэлүүд / Ред. Г.Жавзмаа, Г.Батхишиг.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 392х.- ISBN 978-99978-3-186-6.

Энэ номонд зохиогч улс төрийн чиглэлээр бичсэн нийтлэлүүдээ багцлан оруулжээ. Нийтлэл бүрт тухайн асуудлын бодит дүр төрх, үүссэн шалтгааныг тодруулах, оновчтой шийдэхийн төлөө онол болон бусад улс орнуудын туршлагад суурилан, тоо баримттай бичсэн. Түүнчлэн Монголын улс төрийн буюу эрх мэдлийн хүрээнд бий болсон саад бэрхшээлийг даван туулахын тулд, юуны өмнө төрийн эрх мэдлийг авдаг цорын ганц институт болох улс төрийн намуудыг сахилга баттай болгох асуудлыг чухалчлан хөнджээ.

66

Ж-316

/НХУУТ-3ш/

ЭШФ Б-29034-29035


Монгол Ц. **Бодит ардчилал** / Ред. М.Солонго, Д.Ичинхорлоо, М.Ариунаа, М.Амгалан.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 112х.- ISBN 978-99973-3-227-1.

Уг бүтээлд “Ардчилал” гэдэг үгийн утга, ухагдахууны гарал үүслээс эхлээд өнөө үеийн ойлголт, ардчилсан нийгмийн бүтэц, зохион байгуулалт, ардчиллын үндсэн хэлбэр, түүний төлөвшил зэрэг үндсэн асуудлыг өрнөдийн сонгодог онолын бүтээлүүдэд тулгуурлан оновчтой илэрхийлсэн байна. Тэрээр Монгол улс дахь ардчиллын түүхэн замнал, өнөөгийн байдлыг судлаачийн байр сууринаас авч үзсэнд энэ бүтээлийн үнэ цэнэ оршино.

66.2

М-692

ХЗС 21071-21075





Олбрайт М. **Анхаар: Фашизм** / Орч. Т.Ариунсанаа, Ред. Б.Болдбаатар, Б.Батбаяр.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 302х.- ISBN 978-99978-51-71-0.

Фашизм XX зуунд хэрхэн хөгжсөн, үүний үр хөврөл өнөөгийн дэлхийд нөлөөлж байгаа талаар хувийн үзэл бодлын үүднээс цаг алдалгүй илэрхийлэх гэж энэхүү бүтээлийг Америкийн хамгийн нэр хүндтэй төрийн түшээ, АНУ-ын төрийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хамгийн анх хашсан эмэгтэй бичжээ. Энэхүү номдоо хүүхэд насаа дайнд нэрвэгдсэн Европт өнгөрүүлж, сүүлд нь дипломатчийн шатаар дээш өгссөн Мадлэн

Олбрайт энэ тухайд хувийн амьдрал, туршлагынхаа үүднээс өгүүлжээ. Түүнийхээр фашизм XX зуунд устан үгүй болоогүйгээр барахгүй өдгөө дэлхийн II дайнаас хойш анх удаа дэлхийн энх тайван, шударга ёсонд урьд байгаагүй их аюул учруулж эхлээд байна...

66.2

О-21

/НХУУТ-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-29217-29219

**Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эрхзүйн байдал, төвлөрлийг сааруулах нь** / Ц.Жаргал, Т.Төмөрбаатар, М.Долгорсүрэн, А.Цанжид.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- (Шинжлэх ухааны академи. Философийн хүрээлэн).- ISBN 978-99978-4-071-9.

Зохиогчид энэхүү нэг сэдэвт зохиолдоо нь нутгийн удирдлагын асуудлыг онол номлол, дэлхийн туршлага, сургамж гэх мэтээр нэлээд өргөн хүрээнд харж, өөрийн орны нөхцөлтэй харьцуулан судалсан олон төрлийн судалгааны үр дүнгээ багтаан эмхэтгэжээ.



66.2

3-311

/НХУУТ-5ш/

ЭШФ Б-29204-29208



Хэрлэн Г. **Засгийн газар: 1990-2016: Баримтын эмхэтгэл: I** / Ред. П.Алтанзаяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 524х.- ISBN 978-9997-84003-5.

Энэхүү бүтээл нь залуу хойч үедээ Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд төрийн зүгээс хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний өнгөрсөн 26 жилийн түүхийг танин мэдүүлэх, нөгөөтэйгүүр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагад сонгогдож, томилогдон ажиллаж байгаа, ирээдүйд ажиллах хүмүүсийн ажил үйлст нь сургамж, тус нэмэр болох зорилгыг агуулсан.

Эмхтгэлд Улсын Их Хурлын Тамгын газрын архивт хадгалагдаж буй УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн холбогдох дугааруудыг эх сурвалж болгон авч ашиглажээ. Түүнчлэн 1990 оноос хойших Монгол улсын нэгдсэн төсөв, түүний гүйцэтгэлтэй холбогдсон илтгэл, шийдвэрүүдийг багтаасан.

66.3(1)

X-916

/НУУТ-5ш, ХЗС-1ш/

ЭШФ Т-22467-22470

Хэрлэн Г. **Засгийн газар: 1990-2016: Баримтын эмхэтгэл: II** / Ред. П.Алтанзаяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 658х.- ISBN 978-9997-84003-5.

Энэхүү бүтээл залуу хойч үедээ Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд төрийн зүгээс хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний



өнгөрсөн 26 жилийн түүхийг танин мэдүүлэх, нөгөөтэйгүүр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагад сонгогдож, томилогдон ажиллаж байгаа, ирээдүйд ажиллах хүмүүсийн ажил үйлст нь сургамж, тус нэмэр болох зорилгыг агуулсан. Эмхтгэлд Улсын Их Хурлын Тамгын газрын архивт хадгалагдаж буй УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн холбогдох дугааруудыг эх сурвалж болгон авч ашиглажээ. Түүнчлэн 1990 оноос хойших Монгол улсын нэгдсэн төсөв, түүний гүйцэтгэлтэй холбогдсон илтгэл, шийдвэрүүд, АИХ-ын 12 дахь удаагийн болон УИХ-ын 6 удаагийн сонгуулийн дүнгээр байгуулагдсан Засгийн газруудын үйл ажиллагааны хөтөлбөрийг багтаасан.

66.3(1)

X-916

/НУУТ-5ш, ХЗС-1ш/

ЭШФ Т-22471-22474



Төмөрхүлэг Т. **Бага орны дотоод зовлон**: Монголчуудын жишигээр.- УБ.: Адмон принт, 2018.- 183х.- ISBN 978-99978-2-681-7.

Зохиогч энэ номондоо өөрийн амьдралын урт замд тохиолдсон үнэн бодит явдал, сонссон дуулсан, харж ажигласан бүхнээ, монголчуудын өгөөмөр сэтгэл, чин үнэнч байдал, үүний сацуу монголчуудын дотор өдгөө амь бөхтэй оршиж байгаа гэм согогийг гярхай ажиглаж, түүнд эмзэглэж, түгшиж явдгаа тэмдэглээд, өнөөдөр Монголчууд бидний өөдлөн хөгжихөд сэтгэх арга (mentality) маань чөдөр тушаа болоод байгааг онцлон дурдажээ.

66.3(1)

M-587

/ОУХНУС-5ш/

ЭШФ Б-29197-29198

Дашцэвэл С. **Хо Ши Мин амьдрал, цаг үе**: Зовлон жаргалын гишгүүр дээр ээлжлэн хөл тавьсан энгийн атлаа аугаа хүн / Хян. Ж.Болдбаатар, Э.Энэрэл.- УБ.: Бемби сан, 2015.- 212х.- (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. Олон улсын харилцааны хүрээлэн. Вьетнам судлалын төв).- ISBN 978-99962-3-349-4.

Энэ номонд Хо Ши Миний бага, залуу насны амаргүй амьдрал, хилийн чанадад гарч хар бор ажил хийн өлмөн зэлмэн голоо зогоож, нийгмийн дарлал, харийн колончлолын эсрэг тэмцэлд хэрхэн оролцох болсныг энгийн ойлгомжтой, уншигчдын сэтгэлд хүрэхээр өгүүлжээ. Эл номын нэг онцлог бол Монгол улсад хийсэн Хо Ши Миний айлчлал, олон шижимээр манай ард түмэнтэй хэрхэн холбогдож байсныг эш баримттай өгүүлсэн явдал юм. Хо Ши Миний амьдрал тэмцлийн тухай энэ ном монгол түмэн, нэн ялангуяа улс төрийн залуу зүтгэлтнүүдэд үлгэр дууриал, сургамж өгөх чухал ач холбогдолтой бүтээл болсон.

66.3(5Вье)8

Д-397

ЭШФ Т-22409-22411



Бэгзжав Л. **Монгол, Хятадын харилцаа**: 1949-1999 / Ред. Ч.Далай.- УБ.: ТЭПЭ., 2018.- 122х.- (Шинжлэх ухааны академи. Олон улсын харилцааны хүрээлэн).- ISBN 978-99978-4-693-8.

Монгол, Хятадын албан ёсны баримт бичиг ном хэвлэл, архивын материалд тулгуурлан тавин жилийн түүхийг цаг үе, бодит байдал, хүчин



зүйлийн харилцан нөлөөлөлийг судалж, нэгтгэн дүгнэх, хуримтлуулсан туршлага, үнэт зүйл, түүхэн сургамжийг нээн харуулах, хөгжлийн шинэ нөхцөл, боломж, чиг хандлага, хэтийн төлөвийг шинжлэн тодруулах, Монгол улсын гадаад харилцааны түүхийг цогц байдлаар судлахад нэмэр болох үүднээс энэхүү судалгааны бүтээлийг толилуулж байна.

66.4

Б-922

/ОУХНУС-5ш/

ЭШФ Т-22637-22638

Хайсандай Л. ба бус. **Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (АПЕК) ба Монгол Улс:** Судалгаа, дүн шинжилгээ / В.Энхболд, О.Эрдэнэчимэг; Ред. Г.Чулуунбаатар, О.Хатанболд.- УБ.: Тод бичиг, 2016.- 118х.- (Монгол Улсын Шинжлэх ухааны академи. Философийн хүрээлэн. Олон улсын харилцааны хүрээлэн. ҮАБЗ-ийн дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэн).- ISBN 978-99978-4-044-8.




Монгол Улс АПЕК-д гишүүнээр элсэх үндэсний чадавхийг бэхжүүлэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааг нарийвчлах шаардлагаар Монгол Улсын Засгийн газар шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлсний нэг үр дүн нь энэхүү товхимол болно. Товхимолд тухайн чиглэлээр хийгдсэн гол үр дүн, олон нийтэд хүргэх шаардлагатай зарим мэдээлэл, төр засгийн анхааралд толилуулах санал зөвлөмжийг хураангуйлан оруулжээ.

66.4(0)

Х-177

/ОУХНУС-10ш/

ЭШФ Т-22639-22640



Дашцэвэл С. **Монголчууд ба Зүүн Өмнөд Азийнхан:** Эртний хамаарал, эдүгээгийн харилцаа / Хян. Ж.Баясах.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 341х.- (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. Олон улсын харилцааны хүрээлэн. Вьетнам-Зүүн Өмнөд Ази судлалын төв).- ISBN 978-99978-3-775-2.

Зохиогч энэ номондоо Төв Азийн нүүдэлчин монголчууд Зүүн Өмнөд Азийн бүс нутгийнхантай эрт дээр цагаас хэрхэн холбоо харилцаатай байсан, Монголын эзэнт гүрэн болон Зүүн Өмнөд Азийн төр улсууд хоорондын харилцааны олон сонирхолтой баримтыг судлан шинжилж хэд хэдэн чухал дүгнэлт хийсэн төдийгүй эдгээр улсуудын орчин үеийн харилцаанд анхаарал хандуулж хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх нөхцөл боломжийн талаар санал бодлоо дэвшүүлжээ.

66.4(1)

Д-397

ЭШФ Т-22453-22455

Ломбо Ж. **Монгол улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын харилцаа:** Далан жил / Ред. Л.Хаш-Эрдэнэ; Хян. Я.Сумъяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 384х.- (Монгол Улсын Гадаад Харилцааны Яам).- ISBN 978-99978-3-806-3.



Энэхүү номонд Монгол улс, БНАСАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойшхи далан жилийн түүхэнд хамрагдах баримт бичиг, үе үеийн удирдагчдын хийсэн харилцан айлчлалын үед хэлсэн үг, байгуулсан гэрээ, хэлэлцээр, харилцааны түүхийг бүтээхэд оролцож явсан ахмадууд болон залуучуудын




дурсамжийг эмхэтгэн оруулжээ. Хоёр орны харилцааны түүхэнд холбогдох зарим баримт, эх сурвалж цагийн эрхээр бүдгэрч ховордсон, цаг хугацааны болон хэвлэлийн боломж зэрэг шалтгаанаар бүрэн хамраагүй учирлах ялдамд хоёр орны харилцааны олон талт хамтын ажиллагаатай холбогдсон асуудлуудыг гүнзгийрүүлэн судалж, дэлгэрүүлж үзүүштэй олон зүйлийг багтаажээ.

66.4(1)

Л-732

ОУХНУС-5328-5352



Ломбо Ж. **Монгол улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын харилцаа:** Далан жил / Ред. Л.Хаш-Эрдэнэ; Хян. Я.Сумъяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 370х.- (Монгол Улсын Гадаад Харилцааны Яам).- ISBN 978-99978-3-807-0.

Энэхүү номонд Монгол улс, БНАСАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойшхи далан жилийн түүхэнд хамрагдах баримт бичиг, үе үеийн удирдагчдын хийсэн харилцан айлчлалын үед хэлсэн үг, байгуулсан гэрээ, хэлэлцээр, харилцааны түүхийг бүтээхэд оролцож явсан ахмадууд болон залуучуудын дурсамжийг эмхэтгэн оруулжээ. Хоёр орны харилцааны түүхэнд холбогдох зарим баримт, эх сурвалж цагийн эрхээр бүдгэрч ховордсон, цаг хугацааны болон хэвлэлийн боломж зэрэг шалтгаанаар бүрэн хамраагүй учирлах ялдамд хоёр орны харилцааны олон талт хамтын ажиллагаатай холбогдсон асуудлуудыг гүнзгийрүүлэн судалж, дэлгэрүүлж үзүүштэй олон зүйлийг багтаажээ.

66.4(1)

Л-732

ОУХНУС-2824-2828

### ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН


**Шүүх эрх мэдэл:** Мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл (2018 № 4) / Ерөн. эрхл. Н.Лүндэндорж.- УБ., 2018.- 144х.- (Шүүхийн ерөнхий зөвлөл).- ISBN 978-99962-3-728-7.

Эмхэтгэлд “Шүүхийн шинэтгэлийн асуудал, шийдэл”, “Шүүх судлал”, “Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ”, “Шүүгчийн индэр”, “Хэргийн хөдөлгөөний удирдлага”, “Шүүгч таны мэдлэгийн санд” гэсэн сэдвийн хүрээнд эрдэмтэн судлаачдын 13 судалгааны өгүүллийг нийтэлжээ.

67

Ш-978

ХЗС 93 21059-21062



Монгол Ц. **Үнэний эрэлд...** / Ред. М.Солонго, М.Амгалан.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 161х.- ISBN 978-9997-3321-72.

Энэхүү товхимолд Ц.Монголын сүүлийн арваад жилд хуульч, өмгөөлөгчийн өргөн мэдлэг, өндөр ур чадвараа ашиглан олон арван мянган иргэн, аж ахуйн нэгжүүдийн зөрчигдсөн эрхийг сэргээн, тэдэнд учруулсан сэтгэл санааны болон эд материалын хохирлыг нөхөн олгуулсан тухай олон жишээ баримтыг эмхэтгэн оруулжээ.

67

М-692

ХЗС 93 21076-21080

**Монгол Улсын Үндсэн хууль: The Constitution of Mongolia /** Эрхл. Ж.Амарсанаа; Хян. П.Очирбат, Б.Чимид; Хөрв. Ш.Чоймаа, Л.Төр-Од.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 43х.- ISBN 978-99978-66-59-2.



Уг номын нэгэн “Шигтгээ”-нд “Монгол Улсын Үндсэн хууль бол алив нэгэн нам, нийгмийн бусад бүлэг давхрааны үзэл суртлын бус, харин нийт ард түмний тусгаар оршин хөгжих язгуур ашиг сонирхол, үндэсний эв нэгдлийг бэхжүүлдэг чанараараа манай ард түмний нэг санаа, нэгдмэл хүслэнг илэрхийлдэг. Түүнийг дээдлэн шүтэхийн учир үүнд оршино” гэж бичжээ. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 онд батлагдсан уг эхээр нь монгол, англи хэл дээр кирилл, уйгаржин монгол бичгээр хэвлүүлжээ.

67.400.1

М-692

ХЗС- 93 21070



**Өнөрбаяр Ч., Бямбажаргал А. Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм.-** УБ., 2019.- 542х.- ISBN 978-99978-4-839-0.

Энэхүү бэсрэг эмхэтгэлээр манай улсын үндсэн хуулийн эрх зүйн салбарт хамаарах эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг нэгтгэн энэ салбарт туурвисан зохиол бүтээлүүд, эрдэмтдийн судалгааны ажлыг олон түмэнд таниулах, үндсэн хуулийн эрх зүй судлаачид цаашдын эрдэм шинжилгээний ажилдаа ашиглах боломжийг бий болохыг зорьсон. Уг эмхэтгэл хоёр хэсгээс бүрдэх бөгөөд тэргүүн бүлэгт “Монголын Үндсэн хуулийн эрх зүйн эрдэмтэд, тэдгээрийн товч танилцуулга, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийг”, хоёрдугаар бүлэгт “Монголын Үндсэн хуулийн эрх зүйн эх сурвалжийн лавлагаа”-г 2018 оны 12 дугаар сарын байдлаар шүүн оруулжээ.

67.400.1

Y-823

ХЗС- 93 21065-21069

**Үзэсгэлэн Ни. БНХАУ ба Монгол Улсын зохиогчийн эрхийн харьцуулалт /** Хян. С.Нарангэрэл.- УБ.: Жиком пресс, 2018.- 200х.- (БНХАУ-ын Өвөр Монголын Санхүү, эдийн засгийн их сургууль. Хууль зүйн сургууль. Монгол Улсын Их Сургууль. Хууль зүйн сургууль).- ISBN 978-99978-4-729-4.



Энэ бүтээлд БНХАУ ба Монгол Улсын зохиогчийн эрхийн объект, эрх зүйн эх сурвалж, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, эрх зүйн хамгаалалтын аргуудын талаар харьцуулан судалж, хоёр хөрш улсын төстэй ба ялгагдах хууль тогтоомж, аль нэгнээсээ суралцах ач холбогдол бүхий эрх зүйн зохицуулалт болон шүүхийн практикийн туршлагад дүн шинжилгээ хийхийг зорьжээ. Тус бүтээл нь зохиогчийн хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээлийн суурь болсон юм.

67.404.3

Y-759

/НХУУТ-2ш, ХЗС-10ш/

ЭШФ Б-29152-29154



Гантулга Н. **Монгол Улсын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй: Ерөнхий анги** / Ред. Ж.Амарсанаа; Зөвл. Х.Ю.Владимирович.- УБ.: Бэмби сан, 2019.- 344х.- (Хууль сахиулахын их сургууль).- ISBN 978-999978-66-77-6.

Монгол Улсын Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн бодлого, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих хяналт шалгалт зэрэг олон асуудлыг зохиогч өнөөгийн шинжлэх ухаан, практикийн ололт амжилт, судалгааны баримтад тулгуурлан өргөн хүрээтэй тусгахын зэрэгцээ өөрийн байр суурь, олон улсын хөгжлийн чиг хандлагыг ч тодотгожээ.

67.408(1)

Г-21

ХЗС-93 21121-21140

Доржпалам Х. **Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги: Онол, практикийн асуудалд.-** УБ.: Соёмбо принтинг, 2019.- 352х.- ISBN 978-99962-75-63-0.

Энэхүү сурах бичиг нь 2015 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн үзэл баримтлал, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил, гэмт хэрэг ба ялын төрөл, эрүүгийн хариуцлага, албадагын арга хэмжээнд орсон өөрчлөлтүүдийг уламжлалт болон орчин үеийн онолд тулгуурлан харьцуулан тайлбарлаж бичсэн анхны бүтээл юм.

67.408(1)

Д-542

ХЗС- 93 21093-21100



Бадам Д. **Насанд хүрээгүй хүнд оногдуулах хорих ялын эрх зүйн зохицуулалт: Нэг сэдэвт бүтээл** / Хян. С.Нарангэрэл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 192х.- (Монгол Улсын Их Сургууль. Хууль зүйн сургууль. Нийтийн эрх зүйн тэнхим).- ISBN 999-780-69-94.

Энэхүү нэг сэдэвт бүтээлээр насанд хүрээгүй хүнд оногдуулах хорих ялын эрх зүйн үндэслэл, зохицуулалтын онцлогийг тухайлан авч үзэж, уг институтын талаарх эрүүгийн эрх зүйн хөгжлийн уламжлал, нийтлэг жишиг, хандлагыг судлан харьцуулж, Монгол улс дахь эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, шүүхийн практикийг шинжлэн судлах замаар уг асуудлыг онол, практикийн түвшинд тодорхойлон гаргахыг зорьжээ.

67.409

Б-153

ХЗС- 93 21101-21120

Бадам Д. **Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй: Тайлбар толь** / Ред. Д.Баярсайхан.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 209х.- ISBN 978-99978-4-542-9.

Энэ номонд эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйд түгээмэл хэрэглэгддэг 400 орчим үгийг сонгон авч тайлбарласан бөгөөд тайлбарыг хийхдээ сонгосон нэр томъёог төдийгүй уг ойлголтод хамаарах мэдээллийг дэлгэрэнгүй



байдлаар авч үзсэн болно. Ингэснээр судлаач нэр томъёоны талаархи онолын ойлголтоос гадна холбогдох мэдээллийг давхар авах боломжтой юм.

67.409я2

Б-153

/ХЗС-20ш, НХУУТ-7ш/

ЭШФ Б-29175-29177



Мөнхболд Г., Мөнхтулга Г. **Ерөнхийлөгчийн хориг** / Ред. О.Батсайхан, Н.Лүндэндорж.- УБ.: МУИС пресс, 2018.- 278х.- ISBN 978-99978-3-914-5.

Энэхүү ном нь ерөнхийлөгчийн хориг тавих эрх, түүний үүсэл, хөгжил, зорилго, зориулалтыг харьцуулсан эрх зүйн үүднээс түүхчлэн судлах аргыг гол болгон авч үзсэний үндсэн дээр Монгол Улс дахь хоригийн институцийн үүсэл, хөгжил, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлон, боловсронгуй болгоход чиглэсэн санал, дүгнэлтийг дэвшүүлэн тавихыг зорьсон нэг сэдэвт судалгааны бүтээл болно.

67.400.6

М-816

/ХЗС-2ш/

ЭШФ Б-29172

Гантулга С., Энхболд Б. **Эрүүгийн эрх зүй: Тусгай анги: Сурах бичиг** / Хян. Г.Гантөмөр.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 572х.- (Хууль сахиулахын их сургууль. Цагдаагийн сургууль).- ISBN 978-99978-3-633-5.

Уг сурах бичиг нь 2015 оны Эрүүгийн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн бичигдсэн анхны сурах бичиг бөгөөд тухайн бүтээлийг Хууль сахиулахын их сургуулийн Гэмт явдал судлалын профессорын судалгааны баг, Редакцийн зөвлөлөөр хэлэлцэж, их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын нэгдсэн бодлогод нийцсэн, эрдэм шинжилгээний бүтээлд тавигддаг нийтлэг шаардлага, “Эрүүгийн эрх зүй: тусгай анги” хичээлийн хөтөлбөрийн агуулгыг бүрэн хангасан гэж үзэж, тус хичээлийн үндсэн сурах бичгээр ашиглахыг зөвшөөрсөн.

67.408

Г-21

ХЗС-93 21052-21056



**“Хар тамхины гэмт явдал: Шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам”:** Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл / Эмхт. Б.Мөнхсэргэлэн, О.Уулзахжаргал; Ред. М.Эрдэнэбаяр.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх, 2018.- 296х.- (Хууль зүй, дотоод хэргийн яам. Цагдаагийн ерөнхий газар. Хууль сахиулахын их сургууль).

Эрдэм шинжилгээний хуралд оролцогчид нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, эрдэм судлаачдын үүрэг өндөр байх ёстойг санал нэгтгэйгээр илэрхийлж, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг боловсронгуй болгоход чиглэсэн тодорхой санал, зөвлөмжийг гаргасныг энэхүү эмхэтгэлээрээ дамжуулан шийдвэр гаргах болон гүйцэтгэх эрх бүхий байгууллагуудад сонордуулахын ялдамд эрдэмтэн судлаач, суралцагч, практик байгууллагын ажилтны үйл ажиллагаа, мэдлэгт тус дөхөм болох зорилгоор хуралд хэлэлцүүлэхээр ирүүлсэн илтгэлүүдээс шалгарсан илтгэлийг эмхэтгэн хүргэжээ.

67.408

X-235

/ХЗС-2/

ЭШФ Т-22551

**Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017** / Зөвл. Г.Эрдэнэбат, Л.Нямгэрэл, Ж.Болдбаатар ба бус; Нэгтг. Б.Мөнхдорж, Г.Оюунболд, Ц.Гантулгатбат ба бус. - УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 237х.- (Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл).- ISBN 978-99978-4-964-9.



Энэхүү товхимолд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, улмаар НҮБ-ийн олон улсын гэмт хэргийн ангилалтай харьцуулагдаж буй байдлыг илэрхийлэх, мөн нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцоолж, гэмт хэргийг тодорхой төрөл, үйлдэгдсэн онцлог, нутаг дэвсгэрийн байдал, гэмт хэргийн нөхцөл байдлыг ойлгомжтой хэлбэрээр системчлэн оруулах, судлаачдын санал, дүгнэлтээс зайлсхийж, гэмт хэргийн нөхцөл байдлыг тоон хэлээр байгаа түвшинд нь бодитойгоор харуулахыг зорьсон нь онцлог болсон.

67.51(1)

М-692

ХЗС- 93 21063-21064

### **СОЁЛ. ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ**



Дорждагва Т. **Соёл судлал: Сурах бичиг** / Эрхл. Д.Мэндсайхан.- 5 дахь хэвл.- УБ.: БИТ пресс, 2019.- 232х.- ISBN 978-99962-59-20-3.

Соёлын мөн чанар, үндсэн ойлголтууд, бүтэц хэлбэр, бие хүн нийгэм, урлаг уран сайхны соёл, соёл ба орчин үеийн тулгамдсан асуудлууд гэсэн агуулгыг багтаасан энэхүү сурах бичгийн нэмэн сайжруулсан тав дахь хэвлэлд агуулгатай холбогдох нэр томъёог монгол-орос хэлээр оруулж, тухайн хичээлээр хийх бие даалтын сэдвүүд болон мэдлэг шалгах асуултууд, уншиж судлах бүтээлийн жагсаалтыг хавсаргажээ.

71.0я73

Д 542

/НХУУТ-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Б-29178-29180

Дулам С. **Домог, бэлгэдлийн ертөнц: Ярилцлагын ном** / Эмхт. Н.Нарангэрэл; Хян. Д.Нямдорж.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 320х.- ISBN 978-99978-4-840-6.



Уг номонд профессор С.Дуламын “Түмэн хэлний яруу найраг” уулзалт ярилцлага, яруу найрагчийн нийгмийн идэвхи, ёс суртахуун, уран чадвар, шинэ сэтгэлгээний тухай ярилцлага, монгол хэлний хөгжлийн зарим тулгамдсан асуудлаар хэл, утга зохиолын эрдэмтэн, мэргэжилтнүүдтэй хийсэн бүтээлч зөвлөлдөөн, Монгол Их цаазын төслийг хэлэлцэх дугуй ширээний ярилцлага, “Олон ертөнцийн ганц хэл”, домог зүй, бэлгэдэл, бөө судлалын талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн талаарх ярилцлагуудыг багтаасан. Түүнчлэн түүний хүүхэд



ахуй наснаас эхлээд амьдрал, бүтээлийг өгүүлсэн фото зургуудыг тайлбарын хамт хавсаргажээ.

71.0

Д 642

/НХУУТ-5ш/

ЭШФ Т-22615-22619

**Дулам С. Соёл, урлаг судлалын сан хөмрөг:** Эрдэм шинжилгээний өгүүлэл: 3 боть / Эрхл. Э.Сонинтогос; Эмхт. Д.Нямдорж, А.Цэнд-Аюуш.- УБ., 2018.- (Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургууль. Монгол Улсын Их Сургуулийн Монгол судлалын хүрээлэн).

СУИС-иас эрхлэн хэвлүүлж буй “Соёл урлаг судлалын сан хөмрөг” цувралаар Монгол Улсын Ардын багш, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор Сэндэнжавын Дуламын эрдэм шинжилгээний өгүүллийн чуулганыг өргөн толилуулж байна.

71.0

Д 642



**Б.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл I (IY) боть:** Бэлгэдэл зүйн судалгаа.- 539х.- ISBN 978-99978-4-606-8.

Цувралын эхний ботид нүүдэлчин монголчуудын өвөрмөц соёл дахь бэлгэдлийн гүн ухаан болон зан заншлын бэлгэдэлтэй холбогдох төрт ёсны, тамга, туг сүлд, тахилгын, тооны, өнгөний, цагийн, үг аялга дуу чимээний, бүжгийн, цагаан сар, цагаан идээний бэлгэдэл гэх мэт монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээний тухай өгүүлэх судалгааны баримтууд оржээ.

/НХУУТ-5ш/

ЭШФ Т-22585-22589

**Б. 2. Эрдэм шинжилгээний өгүүлэл II (Y) боть:** Соёл, урлагийн судалгаа.- 499х.- ISBN 978-99978-4-607-5.

Цувралын дэд ботид Монголчуудын нүүдлийн соёл иргэншил болоод газар эхийн шүтлэг, тахилга, байгалиа хамгаалах уламжлал, монгол хувцас, монгол малгай, монгол хатадын ёс жудаг, монгол угсаатны давсны хэрэглээ, эмчилгээ, дом ширгэлгэ, ардын сурган хүмүүжүүлэх, Шинжаан ойрадын бүжгийн урлаг, Савардангийн түүх домгийн утга бэлгэдэл гэх мэт монгол угсаатны соёл, урлагийн талаар эрдэмтний судалсан судалгааны баримт материал, өгүүллийг эмхэтгэжээ.



/НХУУТ-5ш/

ЭШФ Т-22590-22594



**Б. 3. Эрдэм шинжилгээний өгүүлэл III (YI) боть:** Бурханы шашин, нийгэм, хэл шинжлэлийн судалгаа.- 443х.- ISBN 978-99978-4-608-2.

Цувралын гутгаар ботид судлаачийн Бурхны шашны зарим зохиол бүтээлд хийсэн судалгаа, монголчуудын үзэл сэтгэлгээ, монгол авгайлгын ёс, монгол хэлний эерүүлэн цээрлэх ёс, монгол хэлний дархлаа, орчин үеийн монгол гэр бүлийн уламжлалт харилцааны өөрчлөлт, хөдөөнөөс хотод шилжин амьдрах соёлын ертөнцийн ялгаа, орчин үеийн нийгмийн эмгэг

хам шинж, ирээдүйн төлөв, “Хүмүүний сүйрэл” бодрол зэрэг судалгааны өгүүлэл, тэмдэглэлүүд нь оржээ.

/НХУУТ-5ш/

ЭШФ Т-22595-22599

**Газарзүйн асуудлууд:** Эрдэм шинжилгээний бичиг: 2017 (2) № 17 / Ред. Д.Амартүвшин.- УБ.: МУИС Пресс, 2017.- 125х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Байгалийн ухааны салбар. Газарзүйн тэнхим).- ISSN 2312-8534.

“Хөвсгөл, Булган аймгийн уур амьсгалын онцлог нөхцөл хоорондын харилцан уялдаа”, “Хот, хөдөөгийн зааг бүс дэх газар ашиглалтын өөрчлөлт”, “Гадаад оюутнуудын Өмнөд Солонгос улс дотор аялах зорилго-аяллын давтамжаас хамаарах нь”, “Байгалийн бүс бүслүүр дэх ургамалжлын нормчилсон индексийн өөрчлөлт, түүний уур амьсгалын хүчин зүйлээс хамаарах хамаарал”, “2018 онд зохион байгуулагдах олон улсын хурлууд” сэдвээр бичсэн эрдэмтэн судлаачдын илтгэл өгүүлэлүүдийг энэ дугаарт нийтэлжээ.

72+26.8я5

Г-161

/ЛФ-1ш/

ЭШФ Т-22535-22537



**Газарзүйн асуудлууд:** Эрдэм шинжилгээний бичиг: 2018 (1) № 18 / Ред. Д.Амартүвшин.- УБ.: МУИС Пресс, 2018.- 125х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Байгалийн ухааны салбар. Газарзүйн тэнхим).- ISSN 2312-8534.

“Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Улаан нуурын усны талбайн өөрчлөлт, түүнд нөлөөлөх хүчин зүйлс”, “Хот тэлэлтийг (Sleuth) загвараар таамаглах нь: Улаанбаатар хотын жишээн дээр”, “Тандан судалгааны мэдээллийг ашиглан бэлчээрийн ургац болон багтаамж тодорхойлох нь: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын жишээн дээр”, “Улаанбаатар хотын дулааны арлын судалгаа”, “Улаанбаатар хотын агаарын бохирдолд нөлөөлөх агаар мандлын хүчин зүйл”, “Бэлчээрийн газрын фото мониторингийн судалгаанд суурилсан сэргэх чадавхын дүнгээс: Архангай аймгийн Хотонт сумын жишээн дээр” сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн илтгэл, судалгааны өгүүлэлүүдийг энэ дугаарт нийтэлжээ.

72+26.8я5

Г-161

/ЛФ-1ш/

ЭШФ Т-22538-22540

**Газарзүйн асуудлууд:** Эрдэм шинжилгээний бичиг: 2018 (2) № 18 / Ред. Д.Амартүвшин.- УБ.: МУИС Пресс, 2018.- 177х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Байгалийн ухааны салбар. Газарзүйн тэнхим).- ISSN 2312-8534.

“Туул голын гадаргын болон газар доорх усны хамаарлыг, гидрохимийн үзүүлэлтүүдийг үндэслэн тодорхойлсон дүнгээс”, “Цагаан давааны төвлөрсөн хогийн цэг орчмын хөрсний бохирдол”, “Малын тооны бүлэглэлтээс үүдэн малчдын нүүдэлд гарч буй өөрчлөлт”, “Нутаг дэвсгэрийн хөгжлийн судалгааны аргазүйн асуудал”, “Гоозүйн аялал рекерацийн нөөцийн чадавхын үнэлгээ (Увс




аймгийн жишээн дээр гэх мэт сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн илтгэл өгүүлэлийг сэтгүүлийн энэ дугаарт нийтэлжээ.

72+26.8я5

Г-161

/ЛФ-1ш/

ЭШФ Т-22541-22543



**Социологи:** Эрдэм шинжилгээний бичиг: № 12 (500) / Эрхл. О.Мөнхбат; Ред. Ц.Болд, Д.Мөнхтөр, Я.Отгонбаяр.- УБ.: МУИС Пресс, 2019.- 264х.- (Монгол Улсын Их Сургууль. ШИНЖЛЭХ ухааны сургууль. Нийгмийн ухааны салбар).- ISSN 2307-2253.

Сэтгүүлийн энэ дугаарт социологийн онол, түүх, салбар социологи гэсэн 2 бүлэгт багцлан эрдэмтэн судлаачдын бичсэн “Никлас Луман: Эрх зүй - нийгмийн харилцамжийн “автопоэтик систем” болох нь”, “Сүлжээний онол хийгээд дижитал социологи”, “Социологи дахь зөрчилдөөний онолын талаарх үзэл баримтлалууд”, “Монгол дахь ЖДҮ-эрхлэлтийн эрх зүйн орчны социологийн шинжилгээ”, “Уул уурхайн шийдвэр гаргалтанд талуудын оролцооны мэдлэг, хандлага, дадалд хийсэн социологийн шинжилгээ”, “Монголын нийгмийн сайн сайхан байдал” зэрэг 25 судалгааны өгүүлэл хэвлэгджээ.

72+60.5я5

С-61

/НХУУТ-2ш, ЛФ-1ш/

ЭШФ Т-22555-22556

**Эдийн засаг: Онол, практик:** Эрдэм шинжилгээний бичиг: № 31 (493) / Ред. Б.Алтанцэцэг.- УБ.: МУИС Пресс, 2018.- 108х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Эдийн засгийн тэнхим).

Энэ удаагийн дугаарт макро эдийн засгийн сүүлийн үеийн загваруудын нэг болох динамик стохастик ерөнхий тэнцвэрийн загвар, өсөлтийн эх сурвалжийн шинжилгээ, хүн ам зүй болон цаг уурын өөрчлөлт нь өрхүүдийн хэрэглээнд үзүүлж буй нөлөөг Монголын хувьд судалсан судалгааны гурван ажлыг нийтэлжээ.

72+65

Т-19

/НХУУТ-3ш, ЛФ-1ш/

ЭШФ Т-22501-22503



**Эдийн засаг: Онол, практик:** Эрдэм шинжилгээний бичиг: № 32 (504) / Ред. Б. Алтанцэцэг.- УБ.: МУИС Пресс, 2019.- 90х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Эдийн засгийн тэнхим).- ISSN 2617-247X.

Сэтгүүлийн энэ дугаарт Б.Соёлмаагийн “Авлига болон хүнд суртлын орлого, хуваарилалтанд үзүүлэх нөлөө”, Ө.Мөрөнгийн “Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлыг дэглэм солигдох загвараар загварчлах нь”, Б.Гарамжавын “Монгол Улсын мөнгөний эрэлтийн тогтвортой байдал ба санхүүгийн инноваци” сэдэвт судалгааны бүтээлүүдээс гадна сэтгүүлд бүтээл ирүүлэх урилга, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн танилцуулгыг оруулжээ.

72+65

Э-21

/НХУУТ-3ш, БС-3ш, ЛФ-1ш/

ЭШФ Т-22666-22668

**Политологи:** Эрдэм шинжилгээний бичиг: № 16 (489) / Эрхл. Ж.Төртогтох.- УБ.: МУИС пресс, 2018.- 198х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Нийгмийн ухааны салбар).- ISSN 2227-6904.



Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн онол, үзэл баримтлал, улс төрийн институт, ардчиллын онол, практик, харьцуулсан улс төр, эмпирик судалгаа, улс төрийн түүх, нэр томъёоны тайлбар зэрэг улс төрийн шинжлэх ухааны олон чухал сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн өгүүлэлүүдийг нийтэлсэн байна.

72+66

T-73

/НУУТ-3ш, ЛФ-1ш/

ЭШФ T-22495-22497



**World Affairs:** Эрдэм шинжилгээний бичиг: 2017 № 2/34 (502) / Edit. S.Battulga.- UB.: NUM press, 2017.- 122p.- (National University of Mongolia. School of International Relations and Public Administration).- ISSN 2308-9040. The journal covers the issues related to international relations, international political economy, international law and regional and country studies.

72+66.4я5

W-80

/ЛФ-1ш/

ЭШФ T-20036-20038

**Боловсрол судлал:** Эрдэм шинжилгээний бичиг: № 469 (17) / Эрхл. Г.Сарантуяа.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2017.- 262х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Нийгмийн ухааны салбар).- ISSN 1818-8478.



Эрдэмтэн судлаачдын бичсэн “Аз жаргал ба үнэт зүйлсийн баримжааг судалсан нь”, Айдаст нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа”, “Бага бүлгийн сэтгэл зүйн уур амьсгал ба бие хүний зан төлвийн хамаарлыг судалсан нь” зэрэг сэтгэл судлалын - 22, “Англи хэлний хичээлийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох нь”, “Бага насны хүүхдийн хэл ярианы хөгжил төлөвшлийн асуудалд”, “Бизнесийн мэдээллийн систем хичээлээр оюутныг төлөвшүүлэх боломжийг судалсан үр дүн”, “Бүх нийтийн аялал жуулчлалын боловсрол ба дотоодын аялагчдын төлөвшлийн асуудал зэрэг 29 өгүүлэл энэ дугаарт нийтлэгджээ.

72+74

Б-55

/НХУУТ-3ш, ЛФ-1ш/

ЭШФ T22495-22497



**Боловсрол судлал:** Эрдэм шинжилгээний бичиг № 486 (18) / Эрхл. Г.Сарантуяа.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2018.- 230х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Нийгмийн ухааны салбар).- ISSN 1818-8478.

Боловсрол судлалын чиглэлээр эрдэмтэн судлаачдын бичсэн “Аутизмтай хүүхдүүдэд зориулсан “Сэдэвт тоглоом” сургалтыг туршсан үр дүн”, “Байгууллагын соёлд хамт олны сэтгэл зүй нөлөөлөх нь”, “Банк санхүүгийн салбарт тохирох үйлчилгээний ажилтны зан төлөвийг судалсан үр дүн” зэрэг сэтгэл судлалын-19, “Англи хэлний багш” мэргэжлээр төгсөгчдийн сэтгэл ханамжийн

асуудалд”, “Англи хэлний хичээлийн шалгалтын оновчтой хэлбэр, үнэлгээний бодит байдал”, “Ард түмний хэлний боловсролд монгол хэлний гажилт (Paradox)-ын мэдлэг чухал болох нь” гэх мэт 21 өгүүлэл энэ дугаарт нийтлэгджээ.

72+74

Б-55

/ЛФ-1ш/

ЭШФ Т-22489-22491

**Боловсрол судлал:** Эрдэм шинжилгээний бичиг: № 21 (503) / Сэтгүүлийн зөвл. Б.Баяртогтох, Б.Отгонтөгс, Ч.Лхагважав ба бус.; Ред. зөвл. Аму В.М. Tsui, Yurawal Klaimongkol, Ц.Бурмаа, Р.Чанцалдулам ба бус.- УБ.: МУИС пресс, 2018.- 47х.- (Монгол Улсын Их Сургууль).- ISSN 1818-8478.

Боловсрол судлалаар эрдэмтэн судлаачдын бичсэн “21 дүгээр зууны монгол суралцагчийн компетенцийн тоонон загвар”, “Хүүхдийн боловсрол дахь эцэг эхийн оролцоог хэмжих загварын найдвартай байдал”, “Business decision making and spatial data analysis with gis”, “Implementing process writing method in traditional class”, “Оюутнуудын сургалт удирдах системийг цаашид хэрэглэх зорилгод нөлөөлөх нөлөөлөл дэх бүлгийн ялгаатай байдал” гэсэн монгол, англи хэл дээрх 5 судалгааны өгүүлийг энэ дугаарт нийтэлжээ.

72+74я5

Б-55

/НХУУТ-3ш, ЛФ-1ш/

ЭШФ Т-22557-22559



**Сэтгүүл зүй:** Эрдэм шинжилгээний бичиг: № 19 (496) / Эрхл. М.Зулькафиль.- УБ.: МУИС пресс, 2018.- 243х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль. Нийгмийн ухааны салбар. Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим).- ISSN 2306-4463.

“Сэтгүүл зүйн арга зүй ба аргыг боловсруулах онол, практикийн зарим асуудалд”, “Блокчэйн технологи сэтгүүл зүйн ирээдүй болох нь”, “Иргэдийн улс төрийн боловсролыг төлөвшүүлэхэд ОНМХ-ийн үүрэг оролцоо”, “Арилжааны телевизүүдийн хөгжлийн чиг хандлага”, “Нийгмийн сүлжээний орчинд сэтгүүлчийн ёс зүйд тулгамдаж буй асуудлууд”, “Нийгмийн сүлжээ сайтууд бизнесийн PR-ын шинэ арга хэрэгсэл болох нь” зэрэг сэтгүүл зүйн онол, практикийн- 12, сэтгүүл зүйн түүхийн- 7, сэтгүүл зүйн шүүмж судалгааны- 9 өгүүлэл энэ дугаарт нийтлэгджээ.

72+76

С-972

/ЛФ-1ш/

ЭШФ Т-22492-22494

**Философи, шашин судлал:** Эрдэм шинжилгээний бичиг: № 20 (498) / Ерөн. эрхл. Б.Дагзмаа.- УБ.: Тото пресс, 2018.- 132х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх ухааны сургууль).- ISSN 2220-959X.

Сэтгүүлийн энэ дугаарт орчин үед идэвхтэй яригдаж байгаа сэдэв болох хиймэл оюун ухаан болон дэлхийн шашин шүтлэгийн нөхцөл байдал, шашны шинэ урсгалыг БНХАУ хэрхэн зохицуулж байгаа тухай, хүрээлэн буй орчны философийн талаарх бүтээлүүд оржээ.

72+86

Э-73

/НХУУТ-3ш, ЛФ-1ш/

ЭШФ Т-22498-22500







**Шинжлэх ухааны академийн Олон улсын харилцааны хүрээлэн: Хагас зууны түүхэн товчоон:** 1968-2018: Түүх, архивын баримт, дурсамж, гэрэл зураг / Эмхт. Л.Хайсандай, Ц.Баатар, Ч.Батцэцэг ба бус.; Хян. Д.Шүрхүү.- УБ.: Бэмби сан, 2018.- 320х.- (Монгол Улсын Шинжлэх ухааны академи. Олон улсын харилцааны хүрээлэн).- ISBN 978-99978-763-1-7.

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс эрдмийн бүтээл туурвилаараа Монголдоо төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэртэй эрдэмтэн мэргэд олноор төрөн гарч, Монголын нийгмийн шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулж ирснийг төр засаг өндрөөр үнэлж ирсэн билээ. Энэхүү бүтээлд эрдмийн их өргөөний хагас зууны түүхийг бүтээсэн, бүтээлцэн үргэлжлүүлж яваа үе үеийн гадаад харилцаа, орон судлалын оюуны ундарга болсон эрдэмтэн мэргэд, түүхт хүмүүсийн туулсан замналын түүхийг хураангуйлан товчоолжээ.

72.3(1)

III-659

/ОУХНУС-1ш/

ЭШФ Т-22633-22634

### **БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН**

**Нээлттэй боловсрол 2019:** Эрдэм шинжилгээний хурлын өгүүлэлийн эмхэтгэл / Дарга А.Амарзаяа; Нарийн бичиг Ц.Навчаа; Гишүүд: Д.Түмэнбаяр, Т.Уранчимэг, А.Эрдэнэбаатар ба бус.- УБ., 2019.- 94х.- (Нээлттэй мэдлэг боловсролын сан).- ISBN 978-99973-0-845-0.

МУИС-ийн Математикийн тэнхим болон “Нээлттэй мэдлэг боловсролын сан”-гаас санаачлан “Нээлттэй боловсрол” эрдэм шинжилгээний хурлыг дөрөв дэх жилдээ МУБИС, ШУТИС, БХ, БМДИ байгууллагуудтай хамтран зохион байгуулсан энэ хуралд боловсролын нээлттэй эх, нөөцүүдийг боловсролд хэрэглэх онол, арга зүй, судалгааны үр дүнг танилцуулж, хэлэлцүүлэх болон эдгээрийг бүх түвшний сургалтад ашиглах боломж, шилдэг туршлагыг танилцуулан түгээн дэлгэрүүлэх зорилгоор хурлын илтгэлүүдийг хоёр үе шаттай хянан магадлаж, сайжруулсан илтгэл өгүүлэлүүдийг эмхэтгэн энэ номонд оруулжээ.




74.0

H-905

/НХУУТ-3ш/

ЭШФ Т-22560-22562



**Алтанцэцэг Ч., Оюунцэцэг Б. Хэл ярианы тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүйн зөвлөмж:** Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш, сурган хүмүүжүүлэгчид, эцэг, эх, багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад зориулав / Ред. М.Батмөнх, Ц.Отгонбаяр.- УБ.: Удам соёл, 2018.- 163х.

Энэхүү гарын авлагыг хэл ярианы бэрхшээлтэй сурагчдад авиан сонсгол хөгжүүлэх, тухайн авиаг хэлэхэд өгүүлэх эрхтэн ямар байрлалд байх, амьсгалын болон өгүүлэх эрхтний ямар ямар дасгал хийх шаардлагатайг тайлбарласан багш нарт зориулсан гарын авлага болгон бүтээжээ. Зохиогч тус гарын авлагаа ОХУ-ын тусгай сурган-сэтгэл судлал, хэл заслын шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан болно.

74.3

A-486

/НХУУТ-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-22462-22466

### СЭТГҮҮЛ ЗҮЙ

Етекбай Т. **Монгол улсын орчин үеийн ном хэвлэлийн үүсэл хөгжлийн асуудал: 1911-1940** / Ред. Ж.Цэзэн.- УБ.: Бэмби сан, 2019.- 311х.- ISBN 978-99978-990-2-6.

Судлаач энэхүү нэг сэдэвт бүтээлдээ Монгол улсын ном хэвлэлийн түүхэнд судлагдаагүй зурвас үе болох 1911-1940-өөд оны түүхэн хөгжил болоод шинэ цагийн ном хэвлэл үүсэх нийгэм түүхийн нөхцөл шалтгаан, соёл, боловсрол, шинжлэх ухаан, нийгэм улс төрийн хөгжилд гүйцэтгэсэн үүргийг судлан тодорхойлохын зэрэгцээ МУ-д хорголжин барын хэвлэх үйлдвэр байгуулагдсан түүх, XX зууны ном хэвлэлийн ажил болон хэвлэлийн ажилтан, мэргэжилтний түүхэн мэдээ баримтуудыг оруулжээ.

76.17(1)

E-800

/НХУУТ-5ш/

ЭШФ Т-29191-29193



### ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Дагдан Д. **Монголын нууц товчоо-ны газар усны нэрийн толь** / Хян. Г.Мажигсүрэн; Зөвл. С.Дамба, Д.Одгэрэлт.- УБ.: Бэмби сан, 2019.- 156х.- ISBN 978-99978-4974-8.

Энэхүү бүтээл нь “Монголын нууц товчоо”-нд мөнхөрсөн газар, ус хаа байна, өдгөө ямар нэр устай болж вэ? гэдгийг өмнөх судлаачдынхаа бүтээл дээр үндэслэн бодит үнэнд ойртуулжээ. Монголчууд эртнээс эдүүгээ хүртэл, “Мөнх тэнгэрийн суу заль, Хөх монголын заяа тэтгэх болтугай”

гэж уул усандаа хүндэтгэл үзүүлж ирсэн сайхан уламжлалтай билээ. Улиран одсон он жилүүдэд Монголын нууц товчоонд гарч буй газар усны үндсэн нэр (жинхэнэ) өөрчлөгдөж эдүүгээ өөр өөр нэр устай болжээ.

81.2М-3

Д-158

ЭШФ Б-29215-29216

Дагдан Д. **Монголын нууц товчоо-нд мөнхрөгчдийн нэрийн толь** / Хян. Г.Мажигсүрэн; Зөвл. Ж.Болдбаатар, Л.Балдан, Г.Гэрэлбаатар.- УБ.: Бэмби сан, 2018.- 144х.- ISBN 978-99978-2-217-8.


Монголын нууц товчоо бүтээл нь зохиогчийн судалгаагаар түм орчим үгнээс бүтэж, гурван мянга орчим үйл явдлаар өрнөж, хоёр мянгаад мөр шүлгээр гоёж гангаран, 81 овог, аймгийг багтааж 140-өөд гол ус, газар нутаг нэрлэгдэж, 32 хот тосгон сүндэрлэж, 22 аргамаг хүлэг морьд янцгааж, Чингис хааны 89 гавъяатан, 78 эцгийн 132 хөвгүүд, 56 эмс охид хатад, Тэмүжин-Чингисийн хүлэг баатар, мянгат, түмтийн ноёд, хишигтэн хэвтүүл, торгууд, хааны алтан ураг, ил нөхөр, далд дайсан, нийт 468 нэртэй, нэргүй хүмүүсийг багтааж, 12 бүлэг, 282 зүйлээс бүрдсэнийг судлан нэгтгэж тус толь бичигт буулгажээ.

81.2М-3



Д-158

ЭШФ Б-29213-29214



Даваасүрэн Б. **Усэг бичгийн үүсэл, хөгжил** / Ред. М.Ууганбаяр.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2019.- 76х.- ISBN 978-99978-67-39-1.

Энэхүү бүтээл нь бичиг үсгийн үүсэл хөгжлийн талаар манай улсад хэвлэгдэн гарч байгаа анхны бүтээл бөгөөд зохиогч энэ номондоо дэлхий дахины бичиг үсгийн түүхийг авч үзэхдээ шумер, ассир-вавилон, урарт, миной, крит, майя зэрэг улс орны ард түмний хэрэглэж байсан үет үсэг болон авианы үсгийг финикийн цагаан толгой гэхчлэн нилээд тодорхой жишээ баримтаар үзүүлсэн байна.

81

Д-121

/НХУУТ- 5ш/

ЭШФ Т-29186-29190

Төмөртоогоо Д. **Монгол хэлэнд орсон гадаад үгийн хураангуй тайлбар толь**. - УБ.: Адмон принт, 2018.- 200х.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол судлалын хүрээлэн).- ISBN 978-99978-3-879-7.

Нийтдээ 1500 гаруй үгийг багтаасан тус толийн толгой үг тус бүрийн ард монгол бичгийн тогтсон бичлэг, тухайн үгийн гарал, дамжиж ирсэн байдал, үндсэн болон хэрэглээний утга, бичгийн дурсгал болон түүхэн сурвалж, утга зохиолоос эшилж авсан бодит жишээ, зонхилох аялгуунуудын дуудлага зэргийг дагалдуулсан. Харин өрнө, дорнын олон хэлний үгсийг тухай тухайнх нь үсгээр бүрэн жигд тэмдэглэх боломж хязгаарлагдмал байгаа учир нийтэд нь латин галигаар тэмдэглэсэн болно. Мөн зарим үгийн гарлын талаар гарсан эрдэмтдийн саналыг харьцуулан дурдсанаас гадна монгол хэлний үгийн гаралын талаар гарсан бүтээлийн ном зүй, товчилсон үгийн жагсаалт зэргийг хавсаргажээ.



81.2Мон-4

Т-587

/НХУУТ-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-22404-22406

## АМАН ЗОХИОЛ. АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ



**Арван зүгийн эзэн Гэсэр хааны тууж оршив:** Монгол Гэсэр цуврал: 9 цувр.- ӨМӨЗО.: Тунляо, 2016.- (Өвөр Монголын Өөртөө Засах орны “Гэсэр”-ийг аварч хамгаалах ажлын төсөл).

2009 онд Шинжлэх ухаан, соёлын байгууллага ЮНЕСКО-гийн биет бус соёлын өвд бүртгэгдсэн Дэлхийн ховор гайхамшигт уран бүтээл гэгдэх Гэсэр хааны тууж нь цар хэмжээний хувьд их урт бөгөөд уг туульд Хурмаст тэнгэрийн хоёрдугаар хүү Үйл бүтээгч “Гэсэр”-ийг хүний ертөнцөд Бурханы зарлигаар буулган мэндлүүлж харгис хүчнийг дарангуйлан, чөтгөр шуламыг арилган, хамаг амьтныг хамгаалан хүний ертөнцийг гай гамшгаас хамгаалсан тухай өгүүлдэг үлгэр юм.

82

А-714

**Лүн Пү Ши хийдийн Гэсэрийн тууж** / Эмхт. Гэрэлт; Хян. Бат, Оньс.- 561х.- ISBN 978-7-5521-0871-2. ЭШФ Б-29055

**Бээжингийн модон барын Гэсэрийн тууж** / Эмхт. Гэрэлт; Хян. Бат, Оньс.- 354х.- ISBN 978-7-5521-0875-0. ЭШФ Б-29056

**Харчин Гэсэрийн тууж: Дээд** / Эмхт. Бу Юу Зу; Хян. Бат, Оньс.- 354х.- ISBN 978-7-5521-0874-3. ЭШФ Б-29057

**Харчин Гэсэрийн тууж: Доод** / Эмхт. Бу Юу Зу; Хян. Бат, Оньс.- 560х.- ISBN 978-7-5521-0873-6. ЭШФ Б-29058

**Цэвээний Гэсэрийн тууж** / Эмхт. Гэрэлт; Хян. Бат, Оньс.- 521х.- ISBN 978-7-5521-0869-9. ЭШФ Б-29059

**Заяын Гэсэрийн тууж** / Эмхт. Гэрэлт; Хян. Бат, Оньс.- 531х.- ISBN 978-7-5521-0880-4. ЭШФ Б-29060

**Устын зуугийн Гэсэрийн тууж** / Эмхт. Гэрэлт; Хян. Бат, Оньс.- 438х.- ISBN 978-7-5521-0870-5. ЭШФ Б-29061

**Номч хатны Гэсэрийн тууж** / Эмхт. Гэрэлт; Хян. Бат, Оньс.- 320х.- ISBN 978-7-5521-0872-9. ЭШФ Б-29062

**Ордос Гэсэрийн тууж** / Эмхт. Гэрэлт; Хян. Бат, Оньс.- 506х.- ISBN 978-7-5521-0881-1. ЭШФ Б-29063

Дулам С. **Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган**: Профессорын эрдмийн өв: 3 боть / Эрхл. Д.Заяабаатар.- УБ., 2018.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол судлалын хүрээлэн). “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цувралаар профессор С.Дуламын эрдэм шинжилгээний өгүүллийн чуулганыг “Домог зүй, бөө мөргөлийн судалгаа”, “Аман зохиолын судалгаа”, “Монгол уран зохиолын судалгаа”, “Бэлгэдэл зүйн судалгаа” гэсэн зургаан ботид багтаан толилуулахыг зорьжээ.

82.3(1)

Д 642



**Б.1: Домог зүй, бөө мөргөлийн судалгаа** / Эмхт. Г.Нандинбилиг, Д.Нямдорж.- 492х.- ISBN 978-99978-4-603-7.

Чуулганы эхний ботид эрдэмтэн судлаачийн домог зүйн бэлгэдэл болон бөө мөргөлийн уламжлалын бэлгэдэл зүйн талаархи эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэлүүд нь орсон байна.

/НХУУТ-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-22600-22604

**Б.2: Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа** / Эмхт. Г.Нандинбилиг, А.Цэнд-Аюуш.- 560х.- ISBN 978-99978-4-604-4.

Чуулганы дэд ботид монгол ардын аман зохиолын онол түүх ба монгол туульс, аман яруу найраг, ардын дуу, үлгэр, түүх домог болон Төв Ази,



Энэтхэг, Төвд, Япон, Солонгос, Геррег домог зүйтэй монгол домгийг харьцуулсан судалгааны өгүүллүүдийг эмхэтгэсэн байна.

/НХУУТ-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-22605-22609



**Б.3.** Монгол уран зохиолын судалгаа, орчуулгын онол / Эмхт. С.Дашдэжид, У.Бямбаям.- 542х.- ISBN 978-99978-4-605-1.

Чуулганы гутгаар ботид Монголын эртний уран зохиолын судалгаа, домог зүйн үндэс, уран зохиолын онол, шүүмж, орчуулгын онол, арга зүйн талаар эрдэмтний өгүүлэмж, тэмдэглэл, харьцуулсан судалгаа зэрэг судлаачийн эрдэм судалгааны чухал үнэ цэнэтэй материалуудыг толилуулсан байна.

/НХУУТ-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-22610-22614

### УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Энхбаяр С., Батсуурь Г. **Утга зохиол шинжлэлийн удиртгал хичээлийн гарын авлага** / Ред. С.Хөвсгөл, Т.Мөнхнаран.- УБ., 2018.- 200х.- (Монгол Улсын Боловсролын Их Сургууль. Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль. Утга зохиолын тэнхим).




Энэхүү гарын авлага нь хичээлийн хөтөлбөрийн дагуу хийгдсэн бөгөөд зохиогч өөрийн багшилж ирсэн туршлага, урд өмнөх үеийн хийгээд өнөө цагийн гадаад, дотоодын судлаач эрдэмтэд, багш нар, уран бүтээлчдийн ном, зохиол бүтээл, намтар тэргүүтний эшлэл, жишээ баримт сэлтэд тулгуурлан бичиж, лекц, семинарын сэдэв, мэдлэг шалгах жишиг тест, хичээлийн хөтөлбөр тэргүүтнийг багтаасан энэ номыг оюутнууд суралцах хугацаандаа төдийгүй төгсөж гараад багш болсон хойноо ч гарын авлага болгон хэрэглэх боломжтой юм.

83.3(0)я7

Э-66

/НХУУТ-3ш/

ЭШФ Т-22407-22408



**Дэлхийн гарамгай найрагч Долгорын Нямаа** / Эмхт. И.Рэнчинханд; Хян. Б.Магсаржав.- УБ.: Удам соёл, 2018.- 414х.- ISBN 978-99978-2-425-7.

Манай нэрт яруу найрагч, шилдэг сэтгүүлч, нийтлэлч Д. Нямаагийн яруу найргийн бүтээл болоод хувь хүн талаас нь түүнийг сайн мэдэх уран бүтээлчид, уншигчдын үг, үнэлгээ, дурсамжийг энэ номонд нилээд дэлгэрэнгүй шингээж өгсөн агаад түүнчлэн хоёрдугаар бүлэгт нь түүний бүтээлийн сороос дээжлэн оруулж, сүүлийн бүлэгт найрагчийн уран бүтээлд судлаач мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ, шүүмж судлалын тойм өгүүллүүд, төгсгөлд нь яруу найрагчийн амьдралын агшинг өгүүлэх фото зургуудыг хавсаргажээ.

83.3(1)

Д-893

ЭШФ Б-29031-29033



**Цэцэн билигт Дархад** / Эмхт. Д.Батжаргал.- УБ.: Бэмби сан, 2018.- 176х.- ISBN 978-99978-4-499-6.

Энэ номонд цэцэн билигт дархад зоны зан заншил, хошин шог яриа, аялгуут сайхан дуу зэрэг биет бус өв соёлыг судлах, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зорилгоор “Маанар” сонинд орсон зарим материалыг зохиогчийн бичсэн цөөн өгүүлэл, дархад шүлэгч, яруу найрагчдын зарим номын өмнөтгөл үгсийн хамт оруулжээ.



83.3(1)

Ц-978

/НХУУТ-5ш/

ЭШФ Б-29064-29068



**Монголын зохиолчдын байгууллагын түүхэн товчоон:** (1929-2018) / Ерөн. ред. До.Цэнджав; Ред. зөвл. А.Эрдэнэ-Очир, М. Саруул далай, О.Содномпил ба бус.- УБ.: Жиком пресс, 2019.- 420х.- (Монголын зохиолчдын эвлэл).- ISBN 978-99978-4-937-3.

Монголын зохиолчдын байгууллага үүссэн цагаасаа монгол улсын нийгэм соёл, улс төр, боловсрол, утга зохиолын хөгжилд оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэлийн талаар энэхүү түүхэн товчоонд өгүүлэх бөгөөд энэ нь

Монголын зохиолчдын байгууллагын түүхийн товчоог дагнан толилуулж буй анхны хэвлэл болмой.

83.3(1)

М 695

ЭШФ Т-22563-22565

## УРАН ЗОХИОЛ

Монголхүү Б. **Нүүдэлчин туульс:** Nomad Epics.- УБ.: Удам соёл, 2018.- 341х.- ISBN 978-99978-2-766-1.


Зохиогч энэ түүвэртээ 60 жилийн туршид тэрлэсэн шүлэг найраглалаасаа зөвхөн өөрийн төрж өссөн нүүдэлчин хоёр ард түмнийхээ ахуй амьдралаас сэдэвлэн бичсэн бүтээлээ шигшиж, Монголын зохиолчдын эвлэл үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойд зориулан өргөн барьжээ.

84(1)-5

М-692

/НХУУТ-2ш/

ЭШФ Б-29040-29042



Зейтен Ж. **Мұралық:** Поэмалар, өлендер, толғаулар: Казах хэлээр / Ред. З.Болат, Б.Алтангүл.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 292х.- ISBN 978-99978-3-291-7.

Ж.Зейтен 1910 жылы Баян-Өлгийге қарасты Цэнгэл сұмында тұган. Баян-Өлгий аймагының жазушылар одагының белсенді мүшесі болған. Мына кітапта Ж.Зейтенін жазған поэмалар, өлендер, толғауларың жинактаған.

Ж.Зейтен нь 1910 онд Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд төрсөн. Тэрээр аймгийн зохиолчдын хорооны идэвхитэй гишүүн байсан. Энэ номонд түүний бичсэн шүлэг, дуу, яруу найргийн бүтээлүүдийг эмхэтгэн оруулжээ.

84(1)-5

3-356

ЭШФ Б-28899-28901

Батбаяр В. **Дотоод ертөнцийн урсгал** / Ред. Ц.Батбаатар, Б.Ерөөлтшагай, Б.Номинчимэд.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 485х.- ISBN 978-99978-4-550-4.

Энэхүү бүтээл нь 1980-аад оны эхээс орон нутгийн болон төвийн хэвлэлүүдэд нийтлэгдэж уншигч олны таашаалд хүрсэн МЗЭ-ийн шагналт, нэрт яруу найрагч, зохиолч Ванхүүгийн Батбаяр агсаны уран зураг шиг дүрслэлтэй, уянгалаг шүлэг, яруу найраг, өгүүллэгийн түүвэр зохиол ажээ.

84(1)-5

Б-332



ЭШФ Б-29209-29210



Батцэцэг Д. **Сэтгэлийн уялга** / Ред. Б.Батхүү; Хян. Ц.Энхтүвшин.- УБ.: Жиком пресс, 2018.- 136х.- ISBN 978-99978-3-933-6.

Яруу найргийн анхны номоо толилуулж буй залуу найрагч Дамдиндоржийн Батцэцэгийн энэхүү бүтээлд монгол яруу найргийн хэм хэмнэлээ алдаагүй, монгол ахуй, монгол агаар салхи сэвэлзсэн, монгол эх хүний, монгол эмэгтэй хүний, сүүн ундаргатай, сэтгэлийн уялгатай хөг аялгуу эгшиглэсэн шүлгүүд багтжээ.

84(1)-5

Б-34

ЭШФ Б-29209-29210

Лермонтов М.Ю. **Чаралба: Шилмэл шүлэг** / Орч. Б.Магсаржав.- УБ.: Удам соёл, 2018.- 302х.- ISBN 978-99973-3-203-5.


XIX зууны Оросын суут яруу найрагч Михаил Юрьевич Лермонтовын хамгийн алдартай зохиолын нэг болох “Демон” буюу “Чаралба” хэмээх романтик найраглалыг нь мөн түүнчлэн зохиогчийн уран бүтээлийнхээ бүх үед бичсэн уянгын шүлгүүдээс нь дээжлэн орчуулснаа, орос эхийнх нь хамт эмхэтгэн, их зохиогчийн мэндэлсний 175 жилийн ойд зориулан хэвлүүлсэн энэхүү номыг уншигч танаа толилуулж байна.

84(2Орос)-5

Л-482

/НХУУТ-2ш/

ЭШФ Б-29052-29054



Отарбаев Р. **Толгой** / Орч. Р. Сураган; Хян. Б.Цогзаяабаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 252х.- ISBN 978-99978-67-74-2.

Зохиолын гол баатар Ноэль хэмээх археологич эрдэмтэн шинээр олдвор нээх хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөн хээрийн шинжилгээний багийнхантай хамтран Казахын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн удирдагч Махамбет Өтемысулын онгоныг нээн, үнэт олдвор олж байгаагаар үйл явдал өрнөнө. Улмаар Махамбет Өтемысулын хөшөө дурсгалыг Алматы хотын нэгэн дүүрэгт сүндэрлүүлж байгаа тухай болон казах ард түмний амьдрал ахуй, ёс

заншлын талаар уг зохиолд сонирхолтой өгүүлжээ.

84(5Каз)-44

О-53

ЭШФ Б-29157-29158

**Цамцаалсан хасын сондор:** Нангиадын Сүн улсын үеийн яруу найраг / Орч. Б.Магсаржав; Хян. Я.Ганбаатар.- УБ.: Удам соёл, 2018.- 216х.- (Монголын соёл, яруу найргийн академи).- ISBN 978-99978-754-1-9.

Дундад эртний Хятадын яруу найргийн алтан үе хэмээн тэмдэглэгддэг Тан улсын үеийн яруу найргийг залгамжлан хөгжүүлсэн Сүн улсын үеийн яруу найргийн голлох төлөөлөгчдийн бүтээлээс энэхүү дэвтэрт толилуулжээ. Номд оруулсан шүлгүүд нь эртний нангиадын уламжлалт **ши, цы** төрлийнх билээ. **Ши, Цы** төрлүүд нь агуулгаараа ялгаатай. Гүн ухааны болон иргэний уянгын агуулгыг **Ши** төрөл илэрхийлдэг бол **Цы** нь хайр сэтгэлийн уянга буюу европ шүлгээр бол романс юм. **Цы** нь хөгжмийн аялгууны дагуу зохиогдож, XII зууны үеийн жүжгийн зохиолын нэгэн хэсэг болж байсан ажээ.

84(5Хят)-5

Ц-178

/НХУУТ-2ш/

ЭШФ Б-29049-29051



**Боланьо Р. Люмпений тууж:** Утга зохиол № 7: Орчин үеийн уран зохиол / Орч. Т.Ариунсанаа; Ред. Г.Сугирагчаа, Н.Жавхлан.- 2 дахь хэвл.- УБ.: Мон судар, 2017.- 104х.- ISBN 978-99973-1-363-8.

Боланьогийн богино хэмжээний сод бүтээлүүдийн нэг болох Люмпений тууж эцэг эх нь замын ослоор гэнэт нас барсны дараа өнчирч хоцорсон эгч дүү хоёр, томоос том Ром хотод хэрхэн аргаа олж, амьжиргаагаа залгуулж буй тухай өгүүлнэ. Энэ орчин үеийн “төлөвшилийн” романаараа Боланьо, порнограф, биеэ үнэлэлт зэрэг эмзэг сэдвийг зоригтойгоор хөнджээ.

84(7Чил)-44

Б-545

/НХУУТ-4 ш, ГНОФ3ш/

ЭШФ Б-29069-29071

**Айтматов Ч. Жамиль:** Утга зохиол № 20: Орчин үеийн уран зохиол / Орч. С.Жамбалдорж; Ерөн. ред. Н.Жавхлан; Ред. Ж. Хишигжаргал, Б.Одончимэг.- УБ.: Монсудар, 2018.- 94х. ISBN 978-99973-1-600-4.

Зохиолын үйл явдал дэлхийн II дайны гурав дахь жилд (1943 он) Киргизстаны тал нутгийн нэгэн тосгонд өрнөж, туужийн гол дүр шударга, хөдөлмөрч, үзэсгэлэнтэй залуу бүсгүй Жамилийн нэгэн сайхан хайрын түүхийг өгүүлэх бөгөөд түүний нөхөр Садык нь нацист Германы эсрэг дайнд явна. Тэр цагт киргиз эрчүүдийн ихэнх нь фронтод тулалдаж байсан учир хүүхдүүд, хүүхнүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд тосгоны тариан талбайд ажиллаж, амьдралаа залгуулж буй үйл явдал үргэлжилдэг. Айтматов зохиолын дүрүүдээ чин сэтгэлээсээ хайрлаж, тун гоёмсог хэл хэллэг хэрэглэснээрээ Жамиль тууж уншигчийн сэтгэлийг гүн татдаг ер бусын нууц оршин буйг судлаачид дүгнэсэн байдаг.

84(5Кир)-44

А-38

/НХУУТ-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-29099-29101





Маркес Г.Г. **Зарлагдсан үхлийн товчоон**: Утга зохиол № 21: Орчин үеийн уран зохиол / Орч. Б.Нямдорж; Ерөн. ред. Н.Жавхлан; Ред. Э.Түвшинбаяр.- УБ.: Монсудар, 2018.- 149х.- ISBN 978-99973-1-588-5.

Маркесын төдий л танигдаагүй богиновтор хэмжээний бүтээлүүдийн дундаас Зарлагдсан үхлийн товчоон (1981) нь хамгийн сод туурвилд тооцогддог. Романы үйл явдал нь Карибын эрэг дэх тосгонд өрнөнө.

Байардо Сан Роман хэмээх залуу нижгэр хурим хийсэн ч сүйт бүсгүй Анхела Викарио нь онгон биш гэдгийг нь мэдээд бүсгүйг төрхөмд нь буцааж, бүсгүйн ихэр ах нь дүүгийнхээ нэр төрийг цэвэрлэхийн тулд буруутай гэгдэх эрийг (Сантьяго Насар) хөнөөж буй үйл явдал гарна. Энэ үйл явдал зөвхөн тухайн гэр бүлд төдийгүй эргэн тойрны маш олон хүмүүсийн амьдралд сөрөг үр дагавар үзүүлж буйг Маркес дахин дахин харуулсаар байсан бөгөөд өнөөдөр бид өөрсдийн үнэлэмж, үзэл хандлага, амиа хичээсэн байдлаасаа болж ямар олон шударга бусын хажуугаар нүдээ аниад өнгөрдөг билээ, тэр шударга бус зөвхөн бусдад бус бидэнд ч нөлөөлсөөр байдгийг харуулсан гэлтэй.

84(7Кол)-44

М-263

/НХУУТ-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-29102-29104

Солженицын А.И. **Иван Денисовичийн нэг өдөр**: Утга зохиол № 22: Орчин үеийн уран зохиол / Орч. Б.Бүдболд; Ерөн. ред. Н.Жавхлан; Ред. Ж.Хишигжаргал, П.Сарангарав.- УБ.: Монсудар, 2018.- 263х.- ISBN 978-99973-1-640-0.

Иван Денисовичийн нэг өдөр зохиол нь 1962 онд Новый мир сэтгүүлд анх хэвлэгдэхдээ Никита Сергеевич Хрущёв (1894-1971)-ын тусгай зөвшөөрлөөр гарч байв. Тус зохиол хэвлэгдэн гарсан нь Зөвлөлтийн албан ёсны хэвлэлд Сталинизмын гэмт хэргийн тухай нийтлэгдсэн анхны тохиолдол байсан бөгөөд олон нийтийг донсолгон, хилийн чанадад шуугиан дэгдээж, урт удаан хугацааны турш байж боломгүй мэт санагдаж байсан утга зохиолын ертөнц дэх тэргүүн зэргийн үйл явдал байлаа. Түүнчлэн Солженицыныг дэлхий дахинд алдаршуулаад зогсохгүй, судлаач шүүмжлэгчид болон түүхчдийн үзэж буйгаар зөвлөлт засаглалыг нуран унахад хамгийн ихээр нөлөөлсөн бүтээл ажээ.



84(2Орос)-44

С-545

/НХУУТ-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-29105-29107



Мэнсфилд К. **Гадаа үдэшлэг ба бусад өгүүллэг**: Утга зохиол № 23: Орчин үеийн уран зохиол / Орч. Н.Сугиррагчаа; Ерөн. ред. Н.Жавхлан; Ред. Б.Одончимэг, П.Сарангарав.- УБ.: Монсудар, 2018.- 248х.- ISBN 978-99973-1-590-8.

Кэтрин Мэнсфилд бол Виржиниа Вүүлфээс гадна англи хэлээр бүтээлээ туурвигч XX зууны хамгийн нөлөө бүхий эмэгтэй зохиолчдын нэг билээ. Ердөө 34-хөн наслахдаа тэрээр модернизмын сонгодог бүтээлд маргаангүй тооцогдох зуу гаруй өгүүллэг бичиж, олон зохиолчдод нөлөө үзүүлсэн. Уран зохиолын чанар чансаа болон уншигдаж, судлагдсан байдлыг харгалзан 12 өгүүллэгийг сонгон энэхүү номонд оруулжээ. Түүврээ 1911 онд бичигдсэн “Мухлагийн хүүхэн” өгүүллэгээр эхлүүлэв.



